

# ЖУАН ФАЛУНЬ

(2-р дэвтэр)

Ли Хонжи

Анх Хятадад 1996 онд  
Бээжинд хэвлэгдэв.

(Монгол орчуулга)

Орчлон ертөнцийн хэр энгүй уудам, сансарын биетийн хэр хэмжээлшгүй том болох нь хүний судлан мэдэж чадах зүйл биш, материйн хэр бичил жижиг болохыг хүн хэзээ ч хэмжин тогтоож бас чадахгүй. Хүний биеийн гүн нууц нь хүмүүний танин мэдэхүйгээс давсан зүйл, хүний мэддэг нь бол үүний зөвхөн өнгөцхөн хэсэг юм. Амь, амьдралын нарийн ээдрээтэй байдал, олон төрөл нь хүн төрөлхтөнд үүрд оньсого хэвээр үлдэнэ.

Ли Хонжи  
1995.9.24

Муу хүнийг атаархал эзэмдэнэ, өөрийн амиа хичээсэн үзэл, уур хилэнгээсээ болж бүхнийг тэр шударга бус гэж үзнэ.

Сайн хүнээс үргэлж энэрэнгүй сэтгэл гарна, гомдол занал бодохгүйгээр зовлон бэрхшээлийг жаргалд үзнэ.

Гэгээрсэн хүнд зууралдсан сэтгэл үгүй, тэр хүмүүний хорвоод төөрөгдөлд унасан хүмүүсийг дуугүй ажиглана.

Ли Хонжи  
1995.09.25

Хэн энгийн хүний зовлон жаргалыг үл хайхарна тэр хүн бясалгагч.  
Хэн хорвоогийн алдах олоход зууралдахгүй байна тэр хүн Архад.

Ли Хонжи  
1995оны 5 сар

## ГАРЧИГ

Даюу ууланд ярьсан ном.....	1
Буддын шашны сургамж.....	8
Хүн төрөлхтний доройтол ба гэгээрэгчид гарах нь .....	11
Эрдэмтэн байх ба бясалгал хийх нь хоёр өөр зүйл. ....	14
Буддын мөн чанар.....	16
Бумбыг бясалгаагүй мөртлөө Бумбад байх .....	18
Хүнийг шавраар бүтээсэн түүх.....	19
Хязгаарлагдмал орчин үеийн шинжлэх ухаан ба гүн гүнзгий бөгөөд өргөн цар хүрээтэй Буддын ном.....	20
Бүх бясалгалын зам эх үндсэндээ буцах .....	23
Даяаны шашны туйлшрал.....	25
Бясалгалын явц дахь түвшин .....	27
Будда ба Бумба.....	29
Ном заах, хүн аврахад үзүүлбэр байхгүй .....	30
Будда хүнд аврал үзүүлдэг, ивээн тэтгэдэггүй. ....	33
Хүн төрөлхтний доройтол ба аюултай үзэл бодол.....	34
Төгсгөлийн галавын үеийн хүн төрөлхтөн.....	37
Жинхэнэ бясалгал .....	40
Ухаалаг бай .....	41
Ухамсар .....	41
Яагаад харагддаггүй вэ? .....	42
Номыг сурах.....	42
Яаж зааварчлага өгөх вэ? .....	43
Хоосон гэж юу вэ? .....	44
Тууштай байх .....	44
Буддын шашин бол Буддын номын хамгийн өчүүхэн, буурай хэсэг юм....	45
Билгүүн ухаан гэж юу вэ? .....	45
Тэтгэвэрт гарсны дараа бясалгах .....	46

## Даюу ууланд ярьсан ном

Зарим хүн нэг амьдралдаа бясалгаад үр дүнд хүрдэггүй, дараагийн насандаа дахин бясалгана гэж хүслээ хэлдэггүй, тэгэхээр дараа нь магадгүй энгийн хүн болж төрнө, дахиад бясалгах боломж олддоггүй. Тэгвэл урьд насанд бясалгасан зүйл нь сайн хувь тавилан болж хувирдаг. Их олон дээд албан тушаалын дарга нар үнэн хэрэгтээ бүгд урд насандаа том лам хувраг байсан хүмүүс байдаг. Тэд бясалгах явцдаа маш их зовлон бэрхшээлийг даван туулсан болохоор нилээд буян хураасан, гэхдээ бясалгалынхаа үр дүнд хүрч чадаагүй учраас том дарга эсвэл хаад, ноёдууд болдог.

Энэ насандаа бясалгаад үр дүнд хүрээгүй ч дараагийн насандаа дахиад бясалгана гэж тангараг өргөвөл энэ нь дараагийн насанд нь учир ерөөлийн айлдал болдог. Тэгээд дараагийн насандаа магадгүй тэр номынхоо үүдэнд үргэлжлэн бясалгана. Тийм тангараг өргөсөн хүн хойд насандаа хүн төрлөө олсны дараа доод түвшний газар доорхи бурхдын хамааралд орохгүй. Багш нь түүнийг хариуцдаг, дараагийн төрлөө олоход нь харж ханддаг. Түүнийг бясалгах боломжтой айлд төрүүлнэ, тэгснээр тэр дахин үргэлжлүүлэн бясалгах боломжтой болно.

Зарим сүм хийдийн олонхи лам хуврагууд бясалгаад үр дүнд хүрч чаддаггүй. Тэдний үр дүнд хүрдэггүй гол шалтгаан нь бол маш олон зууралдсан сэтгэлээ орхиж чадаагүйгээс болдог, яаж бясалгахыг мэддэггүй, мөн Ном олж чадаагүй байдаг. Зарим хүн ном судар уншаад л бурханд бясалгаж болно гэж боддог, гэхдээ энгийн хүний сэтгэлээ орхиж чадахгүй бол бясалгаад үр дүнд хүрэхгүй. Тэр хүн сэтгэлдээ үргэлж Буддыг бодно, иймээс нас барсныхаа дараа бас хийдэд эргэлдээд л байдаг, бусдыг дагаж бясалгахыг бодно. Ийм байдал гардаг. Түүнийг чөтгөр гэвэл чөтгөр биш, лам хувраг гэвэл тэр хүн биш. Хүн төрөлхтөн одоо нэлээд замбараагүй байдалд орсон. Зарим Буддын хөрөг барималд ямар ч Будда байхгүй. Зарим хүмүүс сохроор тахин шүтсэнээс хуурамч Буддыг бий болгосон. Одоогийн зарим хүмүүс модон дээр улаан даавуу уяад тахидаг болсон, уулыг бас хад чулууг тахина. Буддын хөрөг баримал бүтээгдсэний дараа аравнайлагдаагүй бурхан амилаагүй байсан ч тахиж хуурамч Буддыг бий болгодог. Энэ нь Буддатай адилхан харагдана, гэхдээ хуурамч. Ийм их олон төрлийнх байдаг, Буддын дүрээр муу зүйл хийж болно, ийм зүйл маш их байдаг.

Тэнгэрийн оронд жинхэнэ үр дүнд хүрье гэвэл маш хатуу шаардлагатай, хүмүүсийн төсөөлдөг шиг биш. Үнэндээ Буддын шашин одоо төгсгөлийн шатандаа ирсэн, үр нөлөөгүй болсон. Маш олон хүн яаж бясалгахыг мэддэггүй, тэдэнд бясалгахад хэцүү болсон. Буддын шашинд судар номын их олон орчуулга тайлбар гарсан, нэг хувраг нь нэг янзаар тайлбарлаж, нөгөө нь өөр янзаар тайлбарлаад хүнийг зөвхөн төөрөгдөлд оруулдаг, бүгд Буддын номыг сүйтгэж байгаа юм. Хүн Буддын судрыг зөвхөн эх үгнээс нь, үндсэн утгаар нь ойлгох ёстой, тэгвэл тэр

жоохон ойлгож авч чадна, зарчмаас нь бага зэрэг ойлгож авсан ч энэ бол дээш ахилт юм. Дахин уншихад өөр нэг зарчмыг ойлгож авна, энэ нь бас л ахиц юм. Өөр өөр давхаргад өөр өөр ойлголттой болно. Зарим лам хуврагууд Буддын судрыг томъёолсон, бас зарим хүн Буддын номыг тайлбарласан ном бичсэн, тодорхойлолт өгсөн: Буддын энэ үг нь үүнийг хэлсэн, тэр үг нь түүнийг хэлсэн, энэ нь ийм утгатай, тэр нь тийм утгатай гээд л. Буддын ярьсан нь угаасаа өөр өөр давхаргад өөр өөр утгатай байдаг, Рулайгийн түвшин хүртэл тийм байдаг. Гэхдээ маш доод түвшинд бясалгаж байгаа лам хувраг Бодьсадва болон Буддын зарчмыг ухамсарлахгүй. Түүний Буддын сударт өгсөн тодорхойлолт нь үнэндээ түүний өөрийнхөө түвшинд ойлгосон ухагдахуун, хэлсэн үгэнд нь гүн агуулга байхгүй. Энэ нь хүнд их доод түвшний ойлголт өгдөг, тэгээд тэр байранд нь гацаадаг. Үнэндээ энэ нь хүнийг шууд буруу зам руу дагуулж байгаа юм. Тэр Буддын үгийг ийм утгатай гэж ярихад хүмүүс түүний ойлгосон хэмжээнд өөрсдийгээ хязгаарлачихдаг. Тийм ойлголтоор хэн ч дээшээ бясалгаж чадахгүй.

Үеийн үед ийм тайлбар маш их байсан. Үнэндээ хүмүүс “Ганжуур”- Бурханы судар (Гурван сав аймгийн судар), дүрэм тайлалыг ярихдаа Бурханы судрыг дүрэм тайлалтай адилтган үзэж болохгүй. Ялангуяа тайлал бол Буддын номыг хамаагүй тайлбарлаж Буддын номын жинхэнэ утгыг алдагдуулсан. Одоогийн лам хуврагууд орчин үеийн үг хэллэгээр Буддын судрыг тайлбарлахыг оролддог, гэхдээ тайлбарлаж огт чадахгүй. Шагжамүни Буддын ярьсан үг анхны утгаараа л байх ёстой, тайлбарлахад л утга нь хазайдаг. Энэ бол орчин үеийн лам хуврагууд бясалгаад үр дүнд хүрэхэд маш хэцүү болсны нэг учир нь юм. Тэд энэ байдлаас мэддэггүй. Буддын судрын бичигдсэн эртний хэллэгийн утгыг ойлгодоггүй учраас хэл зүйн тайлбар толь хайдаг. Тэдгээр тайлбар тольд зохиогч өөрийнхөө өнгөцхөн ойлголтоор хамаагүй тайлбарласан байдаг. Бүх үед ийм асуудал гардаг байсан, дээр үед ч бас ийм байсан. Дээр үед бичигдсэн номонд харанхуйгаар итгэж болохгүй, тэдгээр нь бас бүгд адилхан, үнэндээ энэ бол Буддын номыг сүйтгэж байгаа юм. Шагжамүни Будда ингэж хэлсэн: Тодорхой жилийн дараа түүний Ном нөлөөгөө алдана, номын төгсгөлийн үе ирэхэд буг чөтгөрүүд номыг бусниулахаар ирнэ. Энэ бол бас нэг учир шалтгаан нь юм.

Лам хуврагуудын хариуцлагагүй байдлаас болж Буддын шашин Энэтхэгт байхгүй болсон юм. Нэг нь ингэж ойлгож, нөгөөдөх нь тэгж ойлгож дураараа болсон. Тэд ингэж янз бүрээр тайлбарлаж Шагжамүни Буддын хэлсэн үгийн жинхэнэ утгыг гажуудуулсан. Иймээс Буддын шашин Энэтхэгт байхгүй болсон.

Та бүгд хоорондоо ойлгосноо хуваалцахад асуудалгүй, энэ нь чи Буддын судрыг яаж ойлгосноо ярьж байгаа болохоор болно, ямар ч муу нөлөөгүй. Харин өөрийнхөө үгийг Буддын судрын үг болгож болохгүй. Өгүүлбэр болгоны үндсэн утга нь чиний зөвхөн тэр түвшинд ойлгосноор хязгаарлагдахгүй, чи ямар нэг

зарчмыг ёстой зөв, сайн гэж ойлгоно. Чи цааш дээшилж дараагийн түвшинд хүрэхэд, тэр үгийн утга нь бүр дээгүүр болохыг ойлгоно.

Шагжамүни Будда 49 жилийн турш номоо заасан, анхандаа Рулай түвшинд хүрээгүй байсан, зарим номоо олон жилийн өмнө ярьсан. Тэр үргэлж зааж байсан, гэхдээ нирваалахаас өмнөх сүүлийн жилүүддээ заасан ном нь урьд заасан номноос нь маш их ялгаатай болохыг ойлгосон. Яагаад гэвэл тэр тасралтгүйгээр танин мэдсээр байсан, тасралтгүйгээр дээшилж, тасралтгүйгээр бясалгаад л байсан. Үнэндээ тэр хүмүүст орчлон ертөнцийн зарчим, номыг үлдээгээгүй. Орчин үеийн хүмүүс үүнийг ном, Бурханы судар гэж ярьдаг. Шагжамүни Буддын үед ямар ч унших судар байгаагүй, харин хойч залгамжлагчид нь Шагжамүни Буддын ярьсан үгийг хожим эргэн санаж бичихдээ зарим буруу зөрүү алдаа гаргасан. Шагжамүни Буддын ярьсан үгийн жинхэнэ утганд зарим өөрчлөлт гарсан, гэхдээ тэр үеийн хүмүүст түүнээс илүү хэмжээнд мэдэхийг зөвшөөрөөгүй. Энэ бүгд санамсаргүй биш, харин зайлшгүй байсан, яагаад гэвэл урьд өмнө хэн ч бясалгалын зүйлийг тов тодорхой бичээд хүмүүст үлдээж зүрхлээгүй, энэ бүгдийг хүн өөрөө ухамсарлан ойлгох ёстой байсан. Хүмүүс төөрөлтийн дунд амьдарч юу ч мэдэхгүй байсан учраас ухамсарлаж ойлгоход хэцүү байсан.

Шагжамүни Будда амьдралдаа үлдээсэн зүйл нь гол төлөв сахил санваарь байсан. Шагжамүни Будда нирваалахад бэлдэж байхад түүний нэг шавь ингэж асуусан: Эрхэм дээд Багшаа, та явчихвал бид хэнийг багшаа гэж үзэх вэ? Шагжамүни Будда хариулсан: “Сахил санваарыг багшаа гэж үз”. Үнэхээр түүний үлдээсэн нь бясалгаж байгаа хүнийг төгс гэгээрэлд хүргэж чадах сахил санваарь байсан. Тэдгээр зүйл нь түүний амьдарч байхад гарсан юм. Хойч үеийн залгамжлагчид нь түүний ярьсан үгэнд үндэслэн зарим зүйлийг бичиж судар болгон үлдээсэн. Би анхны удаа жинхэнэ бясалгалын зүйлийг хүн төрөлхтөнд үлдээж байна, урьд өмнө хэн ч хийж байгаагүй зүйлийг хийсэн, хүмүүнд тэнгэрт гарах “шат” өглөө.

Үнэндээ шашинд хоёр зорилго байдаг. Нэгд нь: Жинхэнэ дээшээ бясалгаж чадах сайн хүнд Бумбад хүрэхэд нь туслах, Хоёрт нь: Хүн төрөлхтний нийгмийн ёс суртахууныг хэвийн өндөр түвшинд барьж байх. Энэ бол шашинд хийх ёстой хоёр зүйл. Үнэндээ миний заан тарааж байгаа нь шашин биш. Гэхдээ Номыг жинхэнэ заан тараах, хүнийг аврахад бас адилхан нөлөө гардаг. Бясалгалаар үнэхээр Бумбад хүрэх замыг нээж өгдөг, мөн Ном сонссон, уншсан олон хүнд энэ зарчмыг ойлгуулдаг. Хэдийгээр тэр бясалгах бодолгүй байсан ч санаатайгаар муу зүйл хийхгүй, хийхийг хүсэхгүй. Энэ нь бас хүн төрөлхтний ёс суртахууныг нэлээд өндөр төвшинд барих нөлөө үзүүлдэг. Бясалгалыг жинхэнэ дэлгэрүүлэх, зааж өгөх нь хүнийг аварч байгаа биш гэж үү?

Зарим өнө эртний үеийн хүн төрөлхтний соёл иргэншил нэлээд урт хугацаанд, зарим нь арай богино хугацаанд үргэлжилдэг байсан. Зарим хүн төрөлхтний соёл

иргэншил их урт хугацаанд үргэлжилсэн. Хүн төрөлхтөн хөгжлийнхөө үе болгонд шинжлэх ухааны өөр өөр замаар явж ирсэн. Одоогийн соёл иргэншлийн хүмүүс орчин үеийн шинжлэх ухааны хүрээнд өөр шинжлэх ухааны хөгжлийн замыг мэдэж чадахгүй. Үнэндээ Хятадын дээр үеийн шинжлэх ухаан одоогийн Европоос дамжиж ирсэн шинжлэх ухаанаас үндсээрээ ялгаатай байсан. Эртний Хятадад хүний амь бие, орчлон ертөнцийг шууд судалдаг байсан. Мэдрэхүйд өртөхгүй, нүдэнд харагдахгүй зүйлийг тэр үеийн хүмүүс судалж зүрхэлдэг байсан, тэдгээрийн оршин байгааг баталж чаддаг байсан. Хүний бясалган суухад гардаг мэдрэмж улам бүр хүчтэй болно, эцэст нь мэдрэмж хүчтэй болоод зогсохгүй тэр нь тэмтрэгдэхүйц бас харагахуйц болж ирнэ. Ингээд биегүй зүйл хэлбэртэй болчихдог. Эртний хүмүүс амьны нууц, хүний бие орчлон ертөнцийн холбоог судлахдаа өөр замыг баримталдаг байсан. Энэ нь өнөөгийн нотлолын шинжлэх ухаанаас үндсээрээ ялгаатай.

Үнэндээ, сарыг өнө эртний хүн төрөлхтөн бүтээсэн юм, үүний доторх нь хөндий. Өнө эртний хүн төрөлхтөн маш их өндөр хөгжилтэй байсан. Одоо хүмүүс Пирамидийг Египтүүд барьсан гэж ярьдаг, чулууг нь хаанаас тээвэрлэж аваачсан болохыг судалдаг, гэхдээ тийм учиртай биш. Энэ бол өмнөх соёл иргэншлийн үлдэгдэл. Нэг үед далайн ёроолд орсон, дараа нь дэлхийд өөрчлөлт гарч эх газрын хавтгай олон удаа өөрчлөгдөхөд дахин хуурай газар гарч ирсэн. Хожим энэ газарт шинэ оршин суугчид олширсон. Тэд аажмаар эдгээр пирамидийн шинж чанарыг танин мэдсэн, дотор нь урт хугацаагаар юм хадгалж болдог, мууддаггүй. Тэд дотор нь хүний цогцсыг хадгалдаг байсан. Пирамидийг тэд бий болгосон юм биш, Египтчүүд үүнийг олсон мөн ашигласан юм. Сүүлд Египтчүүд зарим жижигхэн пирамидыг дуурайлгаж барьсан нь эрдэмтдийг төөрөлдүүлсэн, үнэн учрыг мэддэггүй.

Орчин үеийн хүмүүс юмыг өнөөгийн өнгөцхөн ойлголтоор танин мэддэг, ялангуяа их олон эрдэмтдийн мэдлэгийнхээ хүрээнд гаргасан онол, томъёоллууд нь хүнийг их хязгаарлан боосон. Дарвин хүнийг сармагчнаас үүссэн гэдэг, бүх хүмүүс сармагчнаас үүссэн гэдэгт итгэчихсэн, эцэст нь энэ онолоор янз бүрийн дүгнэлтүүдийг хийсэн. Орчин үеийн шинжлэх ухаан өнөөгийн хүн төрөлхтний соёл иргэншлээс хол давсан зарим зүйлийг олж мэдсэн. Гэхдээ хүмүүс үүнийг хүлээн зөвшөөрч зүрхэлдэггүй, байж болшгүй гэж үздэг, хамаагүй дүгнэлт хийдэг. Ирээдүйд хүний биеийн шинжлэх ухаан гарна. Магадгүй ирээдүйд физик, хими, болон бусад шинжлэх ухааны салбарууд өөр замаар хөгжинө, барууны замаар явах албагүй. Одоогийн нотолгоонд суурилсан шинжлэх ухааны өгсөн дүгнэлтүүд нь маш явцуу, нүдэнд харагддаг, мэдрэхүйд өртдөг зүйлсийг хүлээн зөвшөөрдөг, харин харагддаггүй, баригддаггүй зүйлсийг ер хүлээн зөвшөөрдөггүй. Ийм шинжлэх ухааны дүгнэлтүүд нь ердөө шинжлэх ухааны биш, хүнийг бүрэн хязгаарладаг. Харин шинжлэх ухааны аргаар нүдэнд харагддаггүй, мэдрэхүйд

өртдөггүй зүйлсийг танин мэдвэл тэр жинхэнэ шинжлэх ухаан биш гэж үү? Тэгвэл үүнийг шинжлэх ухаан гэж үзэж болно биз дээ?

Бие бодийг танин мэдэх нь одоогийн эрдэмтдийн танин мэддэгтэй адилгүй. Одоогийн эрдэмтэд нейтрон, атом гэх мэт зүйлийг судлахад аюултай гэж үздэг, хар тугалган хайрцганд тавихгүй бол цацраг идэвхитэй гэж үздэг. Энэ ойлголт бол онол дээр үндэслэгдсэн, тэдний туршилт судалгаагаар нотлогдсон зүйл, тэд зөвхөн ийм багахан зүйлийг л мэддэг. Үнэндээ бие бодь бүхэн амьтай. Шагжамүни Будда бас ингэж ярьж байсан. Аль ч орон зайн биет байсан бодитоор оршдог ба бүгд амьтай. Нейтрон, атом, гамма цацраг болон түүнээс ч микро жижиг хэсгүүдийг бас удирдаж болно, гэхдээ заавал тэр давхаргад хүрэх ёстой. Бидний бясалгалаар гаргадаг гон маш хүчтэй цацраг идэвхт чанартай, бясалгагч түүнийг удирдаж чаддаг. Орчин үеийн шинжлэх ухаан орчлон ертөнцийг ингэж тэгж үүссэн, бүтэц нь ийм тийм гээд л ярьдаг. Дээд түвшний танин мэдэхүйгээр бол орчлон ертөнц нь цаг хугацаа ба орон зайнаас бүтсэн. Үнэндээ орчлон ертөнцийн үндсэн суурь нь энергиэс бүтсэн. Бие бодь улам бичил болох тусам улам хүчтэй цацраг идэвхтэй байдаг, энэ бол хамгийн үндсэн суурийн суурь нь юм. Одоогийн эрдэмтэд үүнийг хүлээн зөвшөөрч зүрхэлдэггүй, яагаад гэвэл энэ зүйлийг танин мэдэж чадахгүй.

Туйлын микро, бичил түвшний матери нь анхдагч материас тогтдог, энэ нь үндсэндээ амьгүй матери юм. Энэ анхдагч материйн хэлбэрийг энгийн хүний ойлголтоор төсөөлж болохгүй. Энэ анхдагч матери бол аймшигтай, дотор нь унасан ямар ч биет хоромхон зуур уусч задарна. Энэ анхдагч материйг шууд хэлбэл матери гэж хэлж болохгүй. Орчлон ертөнцөд Жэнь, Шань, Рэн (Үнэн, Нинжин, Тэвчээр) гэсэн мөн чанар оршдог. Яагаад ямар нэгэн бодисын бичил ширхэг болгонд Жэнь, Шань, Рэн байдаг гэдэг вэ? Жэнь, Шань, Рэн бол хамгийн анхдагч материйг бүрдүүлж бий болгосон, тэр хамгийн анхдагч бие бодийг арай матери гэж нэрлэж болохгүй, энэ хамгийн анхдагч зүйлс нэгдэж хамгийн жижиг эртний материйг үүсгэсэн. Ингэж бүрэлдсэний дараа туйлын жижиг янз бүрийн материйн хэсгүүд нэгдэж янз бүрийн орон зай болгонд орших шороо, чулуу, металын элемент, гэрэл ба цаг хугацаа-орчлон ертөнцийн суурь материал нь болдог. Дараа нь цааш томорч бие бодийн бүр том хэлбэрийг үүсгэдэг, ийнхүү бүх зүйлийг бий болгодог. Тэгэхээр орчлон ертөнцийн түмэн бодис, юм бүхэн энэ мөн чанараас үүсдэг учраас дотор нь энэ орчлон ертөнцийн Номын хязгаарлах чанар жамаараа оршдог. Тиймээс матери болгонд Буддын мөн чанар - Жэнь, Шань, Рэн байдаг, энэ элементээс орчлон ертөнц бүтсэн. Энэ бол Буддын Ном, мөн Дао (Бумба) гэж бас хэлдэг.

Бүх зүйлс амьтай, бүгд Буддын чанарыг агуулдаг, тэдгээр нь зөвхөн сульдаж доройтдог. Үнэн, Нинжин, Тэвчээр мөн чанараас бусад үүсмэл бие бодь сульдаж доройтоход аюултай асуудалтай тулгардаг-тэр биет элэгддэг, ялзран мууддаг, өөрөөр хэлбэл бие бодийн задрал болдог. Бие бодийн задралыг өргөн утгаар хэлбэл



Ном үйлчлэхгүй болсон доод түвшний орчлон ертөнц задран устдаг. Ном хүний сэтгэл зүрхэнд үйлчлэхээ больбол хүний зан чанар муудна, ёс суртахуун үгүй болно. Хүний зан чанар муугүй байхад, ёс суртахуун хэвийн байхад Ном тогтвортой үйлчилсэн хэвээр байна. Нөгөө талаар харвал, хүн зургаан замын тойрогт ямар ч төрөл олсон - ургамал, амьтан, эд материал, цемент, эсвэл элс юу ч байсан түүний нүгэл нь хамт дагаж явдаг. Тиймээс хэрэв хүн төрөлхтөн доройтвол зөвхөн хүний нийгэм доройтсон биш, матери бүх зүйлс бас доройтно. Номын төгсгөлийн энэ үед дэлхий, орчлон ертөнцийн зарим орон зай, цэцэг, өвс, мод бүгдэнд нүгэл оршдог.

Зургаан замын тойрогт хэн нэгэн энэ насандаа хүн болж төрнө, дараагийн насандаа магадгүй амьтан болж төрнө. Зургаан замын тойрог гэдэг ч үнэндээ зөвхөн зургаан төрлийн аль нэгийг олох замаар явах албагүй. Шагжамүни Будда зургаан замын тойргоор явахыг ярьсан. Аливаа амь хүн болж төрж болно, тэнгэрийн хүн болж төрж болно, асуур замын чөтгөр болж төрж болно, мөн амьтан, мал, эд материал гэх мэт болж төрж болно.

Хүн төрөлхтний шинжлэх ухааныг өндөр түвшинд хүргэх гэвэл, эхлээд хүний ёс суртахууны хэм хэмжээг дээшлүүлэх ёстой, эс бөгөөс оддын дайн гарна. Хүн технологийн хөгжлөөр хэзээ ч Буддын түвшинд хүрч чадахгүй. Яагаад вэ? Будда болон тэнгэрийн хүний шинжлэх ухаан технологи нь хүн төрөлхтний технологиос хавьгүй өндөр. Өөрөөр хэлбэл хүн тэр түвшинд зөвхөн хүн төрөлхтний шинжлэх ухаан технологийн аргаар хүрч чадахгүй. Хэрэв хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн тийм дэвшилд хүрч чадвал тэнгэрт үнэхээр гай гамшиг гарна. Яагаад гэвэл хүн техникээр тийм өндөр түвшинд хүрч, тийм аугаа чадварыг эзэмшвэл өрсөлдөх сэтгэл, шунах сэтгэл, завхай сэтгэл, янз бүрийн хүсэл, атаархах сэтгэл, янз бүрийн зууралдсан сэтгэл, алдар нэр ашиг хүсэх сэтгэл гэх мэт янз бүрийн сэтгэлээ бүгдийг нь тэнд аваад очвол тэнгэрт ёстой эмх замбараагүй байдал үүснэ. Иймд үүнийг туйлаас зөвшөөрөхгүй.

Хүн дээш хүрэхийг хүсвэл, тэр цорын ганц зам бол бясалгал л юм. Хатуу тууштай бясалгалын замаар янз бүрийн сэтгэл ба хүслийг орхивол, орчлон ертөнцийн мөн чанар - Үнэн, Нинжин, Тэвчээрт уусвал, тэр өндөр түвшинд хүрч болно. Шинжлэх ухаан гэж юу вэ? Будда, бурхдын эзэмшиж байгаа нь хамгийн дээд гүн шинжлэх ухаан юм. Тэдний материйн талаархи танин мэдэхүй нь их дээгүүр, тодорхой бичил түвшин хүртэлх бие бодийг харж чадна, мөн орчлон ертөнцийн бүр том бие бодийг харж чадна. Одоо хүний мэдэж байгаа бие бодь нь: молекулаас жижиг нь атом..., том нь од гаригсыг хэлдэг, гэхдээ од гаригс хамгийн том бие бодь биш, түүнээс ч бүр том бий. Буддын харж чадах биет нь том нь агуу том, жижиг нь маш бичил байдаг. Гэхдээ ийм хэмжээнд хүрсэн ч Буддууд, Рулай Будда бас анхдагч бичил материйг харж чадаагүй, Рулай бурхдууд орчлон ертөнцийн хэр том болохыг харж чадахгүй.

Тэнгэрийнхэн тэнд бясалгахад их хэцүү гэдэг, бараг бясалгах боломжгүй, яагаад вэ? Яагаад гэвэл Буддад туулах бэрхшээл зовлон байхгүй. Тэнгэрийн Буддад гашуун зовлон байхгүй, зөвхөн таатай, жаргалтай зүйлс байна, хүссэн бүхэн нь байна, амьдрал нь маш их тав тухтай. Чи боддоо, түүнд эгнэшгүй хүчирхэг увьдас чадвар байна, түүнд гай зовлон байхгүй, тэр яаж бясалгах юм? Тийм учраас түүнд дээшлэхэд их хэцүү. Харин хүн бясалгахад нилээд амархан, гэхдээ тийм түвшинд хүрч чадахгүй байвал дээшилж чадахгүй. Яг шавар шавхайгаар дүүргэсэн шилэн лонх усан дээр хөвж чадахгүйтэй адилхан, хүн өөрийгөө ариусгахгүй бол дээшилж чадахгүй.

Буддын аугаа оюун билэг бол түүний түвшний аугаа оюун билэг юм. Рулай давхрагаас хоёр дахин өндөр Будда, Рулай түвшний Будда-гийн орчлон ертөнцийн зарчмыг танин мэдэхээс хавьгүй дээгүүр байдаг. Түүний ярьснаар гурван мянган хорвоо ертөнц элсний ширхэг болгонд байдаг юм биш. Аугаа гэгээрэгч зарим элсний ширхэг дотор, зарим чулуун дотор гурван мянган хорвоо ертөнц байдаг, зарим чулуунд байдаггүй, боржин чулуунд байдаггүй болохыг олж мэдсэн. Зарим чулууг аваад харахад маш уудам орчлон ертөнц харагддаг, дотор нь амьдрагчид нь хүнтэй адилхан. Тэр чулууг шидсэн ч тэд доргилтыг мэдрэхгүй, яагаад гэвэл тийм л орших байдалтай байдаг, хэрэв түүнийг хаа нэгтээ тавьсан ч, усанд хийсэн ч, түүний орон зайд ус орохгүй.

Энэ бол өргөн уудам орчлон. Үнэндээ хүн төрөлхтний аливаа биетийн хэмжээг цэгнэх ойлголт буруу. Энгийн хүний ярьдаг том жижиг гэсэн хэмжээний ухагдахуун оршдоггүй. Чамд биет тийм л харагддаг, гэхдээ энэ нь зөвхөн энгийн хүнд харагдах байдал. Номын бие (Фашэнь) хуудас цаасан дээр, зурган дээр, эсвэл цаасны хоёр грамм хэлтэрхий дээр байж болно. Энгийн хүний ухаан санаанд багтамгүй байдаг, яагаад гэвэл тэр зөвхөн энгийн л хүн.

Үнэндээ дэлхийд бидний энэ материаллаг орон зайд хүн бол цорын ганц хүн төрлийнх биш. Далайд бас хүн төрөлтөн байдаг, урьд хэн нэгэн ингэж ярихад энгийн хүний нийгэм хүлээн зөвшөөрдөггүй, мухар сүсэг бишрэл тарааж байна гэдэг байсан, үнэндээ энэ бол үнэн. Эх дэлхийн хавтгай хөдөлж далайн ёроол дээш өргөгдөн гарч ирэхэд ёроолд нь хүн төрөлтөн байсан, хэдэн төрлийн ч хүн төрөлтөн байдаг. Зарим нь бидэнтэй адилхан, зарим нь биднээс арай өөр харагддаг. Заримд нь заламгай байдаг, зарим нь бэлхүүснээсээ дээш хүний хэлбэртэй, бэлхүүснээсээ доош загасны хэлбэртэй; заримынх нь доод бие нь хүн хөлтэй дээд бие нь загасны хэлбэртэй байдаг.

## Буддын шашны сургамж

Одоо зарим лам хуврагууд зөндөө ном бичсэн, тэд юу бичсэн бэ? Үг өгүүлбэрийн хооронд тэр чигтээ хар, хар чийтэй. Тэд өөрсдөө үүнийг харж чадахгүй, бичсэн зүйлс нь маш замбараагүй. Ийм байдал номын төгсгөлийн үед улам ноцтой болсон.

Шагжамүни Буддын ном Энэтхэгт үүссэн, гэхдээ яагаад Энэтхэгт байхгүй болсон бэ? Шагжамүни Будда амьдарч байх үед хүмүүс түүний заасан дагуу, номын шаардлагын дагуу хийдэг байсан. Шагжамүни Будда номоо айлдаж байх үед хүмүүс ойлгохгүй зүйлээ асуух боломжтой байсан. Хэрэв тэд буруу зүйл хийвэл, Шагжамүни Будда засч өгч байсан. Шагжамүни Будда нирваалсаны дараа маш олон лам хуврагууд Шагжамүни Буддын хэлсэн үгийг өөрсдийн ойлголтоор хамаагүй тайлбарласан. Жишээ нь, Шагжамүни Буддын бясалгалын түвшинг энэ байшингийн өндөртэй зүйрлэвэл жирийн лам хуврагийн бясалгасан түвшин зөвхөн нэг *чи* л (33.3см) гэсэн үг. Тэр Рулай бүтээлийн орон хүртэлх янз бүрийн түвшинд өөр өөрөөр илрэх Буддын номын жинхэнэ утгыг ойлгож чадах уу? Шагжамүни Буддын ярьсан ном нь янз бүрийн түвшинд бясалгах өөр өөр аргыг багтаасан, иймээс бясалгаж байгаа хүн өөр өөр түвшний ойлголтоор дээш бясалгана. Тэр өөр өөр түвшинд бясалгаж хүрэхэд өөр өөр удирдах номтой байсан, иймээс нэг түвшин ахихад Буддын номын адилхан нэг өгүүлбэрээс шинэ ойлголт авч байсан. Буддын судрын эх бичгийг чи унших бүрдээ үргэлж шинэ ойлголтыг авна. Дахин дээшлээд Буддын судрыг уншихад, дахин шинэ ойлголттой болдог. Ингэж тасралтгүй танин мэдэж, өөрийн ойлголтоо байнга шинэчилж дээшлүүлснээр чиний бясалгалын түвшин дээш ахина.

Тэгвэл зарим лам хувраг өөрийнхөө ойлгосноор Буддын судрыг энгийн хүний үгээр тайлбарлавал, эсвэл ном бичвэл хүмүүсийг өөрийнхөө тэр хүрээнд хязгаарлачихна. Тэр Буддын судрын утгыг тайлбарласан. Шагжамүни Буддын айлдсан үг нь маш дээд түвшний, их гүн утга санааг агуулсан, гэвч түүний бясалгалын түвшин их доогуур байсан учраас ойлгож чадаагүй. Хэрэв түүний ярьсан үгэнд Буддад бясалгадаг хүн итгэчихвэл тэр хүнийг өөрийнхөө хязгаарлагдмал ойлголтоор дагуулдаг. Энэ нь өнгөн дээрээ сайн үйл хийж байгаа мэт, хүмүүсийг Буддын номонд суралцахыг дэмжиж байгаа юм шиг боловч үнэндээ Буддын номыг сүйтгэж байгаа хэрэг биш үү? Буддын номыг сүйтгэх хэлбэр нь янз бүр байдаг. Зарим ийм гуйвуулагчид номыг магтахын зэрэгцээ бас үймүүлдэг. Ийм янзын сүйтгэлийг танихад, илрүүлэхэд хамгийн хэцүү, энэ нь хамгийн хор уршигтай. Энэ бол Шагжамүни Буддын ном Энэтхэгт байхгүй болсны гол шалтгаан юм.

Маш олон хүн Шагжамүни Буддын айлдсан зүйлийг тайлбарлах гэж оролддог. Тэд Шагжамүни Буддын ярьсан нь ийм, тийм утгатай гээд л ярьдаг. Тэр нь тэдний

зөвхөн өөрийнхөө түвшинд ойлгосон зүйл юм. Зарим хүний тэнгэрийн нүд нь нээгдсэн, өөр өөр давхаргын зарим үнэн байдлыг харсан, гэхдээ Шагжамүни Буддын Рулай түвшний өндөрт харж чадаагүй, тийм их өндөр орон зайд нэвтэрч чадаагүй. Маш доод давхаргад тэнгэрийн нүд нь нээгдсэн хүн их цөөхөн орон зайг л хардаг, харсан орчлон ертөнцийн орон зай нь маш их доогуур. Яагаад гэвэл өөр өөр давхаргад өөр өөр зарчим байдаг, тэр харснаараа ийм байдаг гэж ярихад үнэндээ тийм байдал биш байдаг. Буддын номыг хамаагүй тайлбарласан хүн бусдыг өөрийнхөө мэдлэгийн хүрээнд хязгаарлчихдаг. Тэгвэл чи хэлдээ, тэр Буддын номыг үймүүлсэн үү, хамгаалсан уу? Тиймээс хэн ч эх судрын нэг үсгийг ч өөрчилж болохгүй! Судрын үндсэн утгаар ойлго, бясалга! Хэн ч өөрийнхөөрөө Буддын номын үгийг хамаагүй тайлбарлаж болохгүй. Харин өөр өөр давхаргын өөрсдийнхөө ойлголтыг хоорондоо хуваалцан ярьж болно: “Одоо би нэг зүйлийг ойлголоо... би ингэж ойлголоо”, “Энэ үг нь надад хамаатай юм байна, миний дутагдлыг хэлж байна, надад үнэхээр хэрэгтэй” гэх мэт. Өөрийгээ дээшлүүлсний дараа судрыг дахин уншихад тэр урдны өгүүлбэрээс шинэ ойлголтыг олж авна. Энэ бол дээшрэлт юм, ингэж л ухамсарлаж ойлгох ёстой.

Одоогийн лам, хуврагууд эсвэл сүсэгтнүүд маш их зүйл бичсэн, тэд бичсэн зүйлээ судар гэж үздэг. Зөвхөн Буддын ярьсан Ном нь судар юм! Тэдний бичсэн зүйлийг яаж сударт тооцож болох юм?! Харин тэд үүнийгээ судар гэж нэрлэдэг. Тэр ч байтугай маш олон сүсэгтэн, хуврагууд нэр ашиг хөөцөлддөг, бас ямбатай, хүмүүс тэднийг сайн гэвэл омогшин хөөрдөг. Бясалгаж байгаа хүн жинхэнэ бясалгах ёстой. Жинхэнэ бясалгал бол хүний зууралдсан сэтгэлийг орхих юм. Энгийн хүмүүсийн дунд нэр ашиг хөөцөлдөх, өрсөлдөх, гайхуулах, атаархах гэх мэт янз бүрийн хүсэл, сэтгэлийг бүгдийг нь орхих ёстой. Энгийн хүмүүсийн дунд өөрийгээ бусдаас илүүд үздэг, мундаг гэж өөрийгээ гайхуулдаг хүн хэр их зууралдсан сэтгэлтэйгээ харуулж байна. Жинхэнэ бясалгадаг хүнд ийм хүнийг харахад хэцүү санагддаг. Эд мөнгөний их шуналтай бясалгагчид бас байдаг, тэд гаднаа ил ярьдаггүй ч өндөр түвшний бясалгагч эсвэл Будда тэдний сэтгэл нэг гарахад л шууд мэддэг.

Энд гол нь сүм хийдэд шавилан сууж бясалгадаг хүнийг ярьж байгаа юм, мөн Буддын шашинд суралцдаг олон хүн бас багтана. Тэгвэл эдгээр хүмүүс Буддад үнэхээр суралцаж байгаа гэж үү? Бясалгагч хүн яах гэж бясалгадаг вэ? Хүн өөрийнхөө зууралдсан сэтгэлээс салахын тулд бясалгадаг. Энгийн хүний хүслийг маш даруу харах ёстой. Номын төгсгөлийн үед Бумбыг олсон их олон хүн яагаад сүм хийддээ байхыг хүсэхгүй алсын уулсыг зорьсон бэ? Тэдний уул, хөвч рүү явах болсон шалтгаан бол хийдийн дотор жинхэнэ бясалгадаггүй их олон хүн байгааг харсан. Сүм хийдийн олон лам хуврагууд их зууралдсан сэтгэлтэй, түүнээсээ салах хүсэлгүй байсан. Тиймээс тэд бие биенээ чадна, хоорондоо эв түнжингүй байсан. Тийм сүм хийд жинхэнэ бясалгалын ариун газар биш болсон учраас жинхэнэ бясалгагчид тэднээс холдсон.

Мэдээж, зарим харгис шашин, ад зэтгэрийн шашин Буддын номыг ил тод бусниулж байгаа. Үүнийг танихад амархан, чи нэг хараад л харгис болохыг нь хэлж чадна. Харин Буддын шашны нэрээр сүйтгэх нь хамгийн аюултай. Яагаад Шагжамүни Будда түүний Ном төгсгөлийн үед хүнийг аварч чадахгүй болно гэсэн бэ? Одоо Номын төгсгөлийн үе. Лам хуврагууд бусдыг аврах нь бүү хэл өөрсдийгөө ч аврахад хэцүү болсон! Би номын төгсгөлийн үеийн байдлыг ярихад зарим хүмүүс гэнэт ойлгосон. Одоогийн нийгмийн байдал маш аюултай болсон. Чи хардаа, хаа сайгүй янз бүрийн худал хуурмаг зүйлс, гажуу, харгис, замбараагүй зүйлс бүгд гарч ирсэн!

Би энд зарим зарчмыг ярилаа, хэн нэгэнд хамааруулж хэлж байгаа юм биш. Олон лам хуврагууд ном бичсэн, өнгөн дээрээ Буддын номыг сурталчилж байгаа мэт боловч дотоод гүндээ нэр ашгийн төлөө юм. Нэг хүн надаас тийм нэгэн хуврагын талаар асуусан, би түүнд чи түүний их нэр хүндтэйг нь битгий хар, буддын судрыг хамаагүй тайлбарлаж өөрийгөө сурталчилсан, үнэндээ тэр аль хэдийн тамд уначихсан гэж хэлсэн.

Судар, жаяг, шаштир гэдгийн Судраас бусад нь бүгд буддын номны эх утгыг сүйтгэж байгаа юм. Одоо зарим хүн үүнийг “гурван савын ном” гэж ярьдаг, үнэндээ “гурван савын ном” биш, зөвхөн Буддын судар юм, судар бол судар. Бусад зүйлсийг судартай адилтгаж болохгүй.

## **Хүн төрөлхтний доройтол ба гэгээрэгчид гарах нь**

Хүн төрөлхтний доройтол нь зөвхөн Есүсийн ярьсан Еве-ийн тэр үеэс эхэлсэн юм биш. Энэ дэлхийд Хүй нэгдлийн үетэй зөвхөн нэг удаагийн соёл иргэншил байгаагүй, харин өнө эртний соёл иргэншил олон удаа байсан, тэд цөм устсан. Заримдаа дэлхий бүрмөсөн устаж, эсвэл бүхэлдээ солигдож шинэ дэлхий бий болдог байсан. Хүн төрөлхтөн дэлхий сөнөх сүйрлийн талаар ярьдаг биз дээ? Үнэндээ энэ нь шашинд яригддаг. Тодорхой нэг хугацаа өнгөрөх бүрт нэг том сүйрэл болдог, тодорхой нэг хугацаа болгонд бага гай гамшиг гардаг. Бага гай гамшиг болоход хүн төрөлхтөний зарим хэсэг устгагддаг. Зарим газарт хүмүүс маш муу болоход тэднийг газар хөдлөлтөөр, эх газар усанд авталтаар, элсэн шуургаар дарж, эсвэл ямар нэгэн өвчин тахал, дайн дажингаар устгадаг. Жижиг гай гамшиг нь хэсэг газрыг хамардаг. Том гай гамшиг нь бараг бүх хүн төрөлхтнийг хамардаг. Тийм том сүйрэл нь маш их урт хугацаанд нэг удаа болдог. Дэлхийн эргэлт бол бас нэг бие бодийн хөдөлгөөн, тэр ч гэсэн зүй тогтолтой байдаг. Энэ эргэлт хөдөлгөөний явцад гардаг том сүйрэлд хүн төрөлхтөн бүрмөсөн устдаг. Гэхдээ цөөн тооны хүмүүс амьд гарч өнө эртний соёлыг уламжилдаг, чулуун зэвсгийн үе шиг байдалд амьдардаг. Яагаад гэвэл хөдөлмөрийн багаж зэвсэг бүгд устсан, дараачийн үеийнхэнд энэ байдал улам хэцүү болно, маш олон зүйлс мартагдахад хүрдэг. Хүмүүс ингэж балар эртний байдлаар амьдарч аажмаар олширно, соёл иргэншил үүсдэг, дэвшилт технологи бий болдог. Дараа нь хүн төрөлхтөн бас доройтоход дахиад гай гамшиг гардаг. Ингэж үүсэл, тогтворжилт, доройтол гэсэн мөчлөгийн үеүд давтагддаг.

Өөрөөр хэлбэл, хүн төрөлхтний доройтол нь зайлшгүй гардаг. Гэхдээ ийм үе болгонд соёл иргэншил үүсэхэд бурхад зарим аугаа гэгээрэгчдийг хүн төрөлхтний нийгэмд ирүүлж хүнийг авруулдаг. Энэ нь хүний ухамсрын доройтол дэлхий дээрх бодис, бие бодийн доройтолтой тэнцвэр алдагдахаас сэргийлэх зорилготой юм. Энэ дэлхийг бүтээсэн орчлон ертөнцийн бүх бодис, бие бодид тусгай мөн чанар оршдог. Энэ мөн чанар байснаар хэлбэр дүрсгүй зүйлийг хэлбэр дүрстэй, амьтай бие бодь болгон хувиргадаг. Гэхдээ бие бодь доройтохоос өмнө, хүн төрөлхтний ухамсар доройтохыг зөвшөөрөхгүй. Иймээс хүн төрөлхтний нийгэмд удаа дараа соёл иргэншил үүсэх бүрт, түүхийн янз бүрийн үеүдэд аугаа гэгээрэгчид ирдэг байсан. Өнө эртний үеүдэд аугаа гэгээрэгчид ирдэг байсан. Энэ удаагийн соёл иргэншлийн үед Есүс, Шагжамүни, Лаози гэх мэт аугаа гэгээрэгчид ирсэн. Өөр өөр үед соёл иргэншил үүссэн газруудад өөр өөр гэгээрэгчид хүнд яаж эх үндсэндээ буцах, үнэнд хүрэхийг зааж өгөх үүрэгтэйгээр ирдэг байсан. Тэд Бумбыг олж авч чадах хүмүүсийг гэгээрэлд хүргэсэн, энгийн хүмүүст яаж буяныг эрхэмлэхийг заасан, хүний ухамсрыг амархан доройтуулахгүйн тулд хүн төрөлхтний ёс суртахууныг нэг тогтвортой түвшинд барьж байхыг шаарддаг байсан. Эцэст нь орчлон

ертөнцийн бүх бие бодь доройтох үе ирэхэд тэд үүнийг хамаарахгүй болдог. Гэхдээ энэ бол маш урт удаан явцтай.

Тухайн энэ үед зарим гэгээрэгчдийн хийсэн зүйл нь: Хүн төрөлхтнийг доройтлоос хамгаалах, үүний дундаас бясалгаж чадах хүнийг бясалгуулаад Бумбыг олох, гэгээрлийн хутагт хүргэхэд байсан. Хүн Дарвины ярьсан шиг бичнээс үүсэлтэй юм биш. Энэ бол хүн төрөлхтөн өөрийгөө гутаасан хэрэг юм. Хүн болгон орчлон ертөнцийн янз бүрийн орон зайнаас энд унаж ирсэн. Орчлон ертөнцийн тухайн орон зайн Номын шаардлаганд нийцэхгүй болоход доош унадаг. Бидний ярьсантай адил, энгийн хүний сэтгэл улам хүчтэй гарах тусам улам доош унадаг. Эцэст нь энгийн хүний энэ байдал хүртэл унасаар ирсэн. Дээд түвшний амь бодийн харснаар дэлхийн хүмүүс хүн байхын тулд дэлхий дээр амьдарч байгаа биш харин дэлхийн ийм нөхцөлд, төөрөгдлийн дунд хурдан ухамсарлаж буцах ёстой юм. Тэд ингэж боддог, тиймээс чамд энэ үүдийг нээж өгсөн. Чи буцаж чадахгүй бол үргэлжлэн төрөл арилжих тойргоор явахаас өөр замгүй, ийм байдал маш их нүгэл хуримтлагдсаар устгагдах хүртэл үргэлжилнэ. Ийм учраас дэлхийд олон удаа гай гамшиг болдог.

Өөрөөр хэлбэл, дэлхий бол орчлон ертөнцийн хогийн хонхор юм. Тоологдошгүй агуу том орчлон ертөнцүүдийн дотор тоологдошгүй оддын аймаг, тоологдошгүй гаригс байдаг, гариг болгон дээр амь амьдрал байдаг. Хүн өөр орон зай байдгийг хүлээн зөвшөөрдөггүй. Иймээс тэдгээр оршиж буй амь бодийг харж чаддаггүй. Зөвхөн манай орон зайд амь бодь оршдог биш, нэг гариг дээр өөр өөр орон зайд бас амь бодиуд оршдог. Иймээс тэд энгийн хүнд харагдахгүй. Жишээ нь: Хүмүүс энэ орон зайд Ангараг гариг дээр их халуун гэдэг, гэхдээ энэ орон зайг нэвтэрвэл тэнд нилээд сэрүүн болохыг мэднэ. Маш олон ер бусын чадвартай хүмүүс нарыг ажигласан, хэсэг зуур харсны дараа нар халуун биш болчихдог, дахиад харахад харанхуй байдаг, дараа нь тэр орон сэрүүн болох нь харагддаг. Энэ материаллаг орон зайд ийм байдлаар оршдог, өөр материаллаг орон зайд өөр байдалд оршдог. Иймээс амь бодиуд хаа сайгүй оршдог, хүн төрөлхтөн бас адилхан. Тэд байгаа давхаргынхаа шалгуурт нийцэхгүй бол бага багаар доош унадаг, муу сурагч улирахтай адил, эцэст нь энгийн хүний давхаргад унаж ирдэг. Орчлон ертөнцийн муу хүмүүс доош унадаг, орчлон ертөнцийн хамгийн төвд - дэлхийд унаж ирдэг.

Хүний хорвоод амьдрахад төрөл арилжих замаар явдаг, тэгэхдээ дахин хүн болж төрөх нь баттай биш. Тэр магадгүй маш олон төрлийн материаллаг биет, янз бүрийн ургамал, төрөл бүрийн амьтан, эсвэл бичил организмын аль нэг нь болж төрнө. Хүний дахин төрөл олох тойргоор явахдаа хийсэн муу үйл нь хамт дагаж явдаг энэ бол нүгэл. Аливаа амь бодийн авч явдаг зүйл нь буян ба нүгэл юм, энэ нь түүнтэй үргэлж хамт, дагаж явдаг. Хэрэв хэн нэгэн их нүглээсээ болж мод болж төрвөл, тэр мод нүгэлтэй болно. Мөн амьтан болж төрвөл тэр амьтан нүгэлтэй болно. Дэлхий дээрх тоосго, шороо, чулуу, амьтан, ургамал бүгдэд нүгэл байдаг.

Яагаад одоогийн эмийг уухад эсвэл тариа тариулахад хуучинтай адил сайн нөлөө гардаггүй болсон бэ? Яагаад гэвэл одоогийн хүмүүс хэтэрхий их нүгэл хийдэг, маш их нүгэлтэй болсон учраас эмний үйлчлэх хүч дутдаг, өвчнийг арилгаж ер чадахгүй. Хэрэв их тунгаар эм уувал тэр хүн хордоно. Одоо үед маш олон эмчлэгддэггүй өвчин гарсан. Бүх дэлхий даяар ийм болсон, үнэндээ бүх зүйлс аюултай хэмжээнд хүртлээ доройтсон.

Есүс хүний төлөө нүглийг нь дааж байсан, Шагжамүни Будда 49 жилийн турш хүнийг аврахдаа их зовлон амссан. Бүх амийг аврахыг ярьсан биз дээ? Тэгвэл тэд яагаад бүх хүнийг дээд тэнгэр лүү авч яваагүй юм? Яагаад гэвэл хүмүүс дээд түвшний шалгуурт нийцэхгүй учраас дээш гарч чадахгүй. Дээд түвшин болгонд өөрийн гэсэн шалгуур байдаг. Хэрэв чи их сургуулийн оюутан байх шаардлага хангахгүй бол тэнд сурч чадах юм уу? Чамд орхиж чадахгүй зүйлс их байна, бие чинь хэтэрхий хүнд, тиймээс дээшилж чадахгүй. Чиний ёс суртахууны хэмжээ аль түвшинд байна, чи тэнд байна. Цорын ганц зам нь боловсрол эзэмшихтэй адил, дээш ахиж чадах нь ахина, бусад нь улам бүр доройтно улмаар устгагдана. Хог илжрээд өмхийрч орчлон ертөнцийг бузарлаж байхыг зөвшөөрөхгүй, зөвхөн устгахаас өөр арга байхгүй.

Рулай (Татагата) түвшний Будда бүх амийг аврахыг ярьдаг, Рулайгаас хоёр дахин өндөр түвшний аугаа Будда энгийн хүний хэрэгт оролцдоггүй. Хэрэв тэр үүнийг хийвэл хэлсэн ганц үг нь энгийн хүний нийгмийг өөрчилж чадна. Тэр хэтэрхий их хүчтэй учраас хүмүүнийг хамаарч болохгүй. Үүнээс бүр дээд Будда-г яривал дэлхий түүнд хэтэрхий жижиг, түүний хөлний нэг хуруу ч багтахгүй. Бүр үүнээс ч том аугаа Будда-г яривал түүний арьсан дээрхи ганц жижигхэн үс ч багтахгүй. Буддын ярьсан үг бол Ном, дөнгөж ярихад л бүх зүйлс өөрчлөгдөнө. Иймээс тийм Будда хэзээ ч дэлхийн асуудлыг хариуцдаггүй. Зөвхөн Рулай болон Бодьсадва нар бүх амийг аврахыг ярьдаг.

Рулай Будда хүнийг энгийн хүн гэж үздэг, харин бүр өндөр түвшинд хүрсэн бурхан Рулайг эргэж хараад энгийн хүнтэй адил авч үздэг. Тийм өндөр түвшний бурханд хүн бол бичил организмд ч тооцогдохгүй, тэр эргэж хараад “Ийм өмхийрсэн газрыг арилга! Бут ниргэ!” гэж хэлнэ. Дэлхий ийм л нэг газар юм. Зөвхөн хүний давхаргад хамгийн ойрхон орших Будда нар хүн төрөлхтнийг өрөвдөнө. Есүс, Рулай давхаргад байсан, мөн Лаози ч гэсэн адилхан. Үүнээс өндөрт байгаа нь хүний хэрэгт оролцохгүй. Хүн түүнийг дуудахад, түүнд сонсогдохгүй, нэрээр нь дуудвал түүнийг доромжилж байгаатай адил. Энэ нь яг ялгадас дотроос гарсан дуу нэрийг нь дуудахтай адилхан.



## **Эрдэмтэн байх ба бясалгал хийх нь хоёр өөр зүйл**

Есүс Рулай түвшинд харъяалагдана. Урьд Рулай бол Буддын хамгийн доод зэрэглэлд байсан. Урьд Рулай-гаас доод зэрэглэлийнхэн Будда гэж нэрлэгдэггүй байсан, тэднийг Бодьсадва, Архад гэдэг байсан. Рулай болгон өөрийн гэсэн тэнгэрийн оронтой байдаг. Бидний энэ Тэнгэрийн заадас галагтиктуу зуу гаруй Рулай байдаг. Өөрөөр хэлвэл зуу гаруй Буддын тэнгэрийн орон, диваажин байдаг. Тийм тэнгэрийн орон болгоныг нэг Рулай удирддаг. Тэнгэрийн орны Рулай болгон өөрийн гэсэн бясалгалын аргатай, хүнийг аврах өөрийнх нь арга байдаг. Өөрийн орныг байгуулах нь түүний бясалгалтай шууд холбоотой. Түүний диваажингийн бүтэц нь бясалгалаар бий болдог. Гэхдээ орчин үеийн хүн бясалгаад тийм орныг бүтээж чадахгүй, тийм диваажин болгон тоологдошгүй миллиард жилийн өмнө бий болсон юм.

Үүнд ийм нэг асуудал байдаг. Энгийн хүн бясалгахад олон бясалгалын аргаас суралцаж, бусад шашны зүйлээс их мэдэж авбал мэдлэгээ улам тэлнэ гэж боддог. Хүмүүс энэ бүгдийг энгийн хүний оюун билиг, мэдлэг гэж үздэг. Үнэндээ энэ нь энгийн хүний мэдлэг биш, энгийн хүний бодлоор ойлгож болохгүй. Бясалгалд яагаад зан чанараа чухалчлах ёстой, Дао-гийн шашинд яагаад буяныг эрхэмлэх ёстой гэдэг вэ? Учир нь энэ орчлон ертөнцөд нэг Ном (Фа) оршдог, нэг мөн чанар оршдог юм. Орчлон ертөнцийн энэ мөн чанар нь өөр өөр түвшинд амь бодь болгонд өөр өөр шаардлагатай байдаг. Энгийн хүний энэ давхаргад байгаа хүн энгийн хүний ёс суртахууны шалгуурт нийцэх ёстой. Хүн өөрийнхээ зан чанарт анхаарахгүй бол яагаад дээшилж чаддаггүй вэ? Яагаад гэвэл энгийн хүний давхрагаас дээш тэнгэрийн хүний шалгуур байдаг, хэрвээ чи тэр түвшний шалгуурт нийцэхгүй бол дээшилж чадахгүй. Яагаад тэнгэрийн бурхан доош унадаг гэж! Сайн бясалгаж чадаагүй Архад яагаад доошоо унадаг вэ? Учир нь тэр түвшний шалгуурт нийцэхгүй болсноос юм.

Энэ тэнгэрийн заадас галагтиктуу зуу гаруй тэнгэрийн орон байдаг, тэнгэрийн орон болгоныг нэг Рулай удирддаг. Тэр тэнгэрийн орны мөн чанар, бүтэц нь түүний бясалгалын аргаар бий болсон юм. Бидний харж байгаагаар шашинд болон бясалгалын бусад аргуудад гаднах хөдөлгөөн нь их хялбархан, завилж суугаад гарын барил хийгээд л болдог. Дао-гийн бясалгалд хэдхэн хялбар хөдөлгөөн хийдэг. Бясалгагч яагаад тийм өндөр, Буддын, Бодьсадва, Архадын түвшинд хүрч чаддаг вэ? Учир нь гоны жинхэнэ хувиралт нь маш нарийн байдаг. Хүний эсүүд хүртэл хувьсах ёстой, их олон увьдас чадвар гарах ёстой, тодорхой түвшинд хамаарагдах хүмүүсийн үл мэдэх маш олон гайхамшигтай зүйлс байдаг, эдгээр бүгдийг бас хувиргаж гаргах ёстой. Харьцуулж хэлвэл эдгээр нь энгийн хүний нийгмийн хамгийн дэвшилт техник төхөөрөмжөөс ч нарийн төвөгтэй, хүн хүрч чадахгүй. Иймээс бясалгалын оронд ийм нэг үг байдаг, “Бясалгал өөрөөс

шалтгаална, гон багшаас шалтгаална.” Өөрөөр яривал жинхэнэ бясалгалын арга, Бумбын сургалтанд бясалгалын зарим аргыг ярьдаг боловч тэр нь зөвхөн төсөөлөл өгөх төдий өнгөцхөн зарчим, зөвлөмж юм. Жинхэнэ дээд энергийн бие бодиос гон бясалгаж гаргах гэвэл заавал өөрийн хүсэл байх ёстой, хийх хүсэл хэрэгтэй. Гэхдээ, өөр орон зайд явагдах гоны жинхэнэ хувирал нь маш нарийн байдаг, хүн хийж чадахгүй, бүгдийг нь Багш хийж өгдөг.

Тэгвэл ийм нэг асуудал байдаг, хэрэв чи өөр номын үүдний зүйлийг хольж бясалгавал асуудал гарна. Урьд лам хуврагуудыг өөр номын үүдний зүйлд хүргэдэггүй байсан. Өнгөрсөн зуунуудад хийдийн доторхи лам хуврагуудыг өөр бясалгалын ном уншихыг хатуу хориглодог байсан. Одоогийн лам хуврагууд замбараагүй болсон. Урьд лам нарт энгийн хүний зүйлс байхыг зөвшөөрдөггүй байсан, өөр бясалгалын номыг үзэхийг хатуу хориглодог байсан. Учир нь, зөвхөн нэг л бясалгалын аргаар нэг номын үүдэнд бясалгах ёстой. Бодол санаандаа зөвхөн нэг номын үүдний зүйлс байлгавал тэр хүн нэг замаар дээш тогтвортой бясалгаж чадна. Харин чи тэгэхгүй өөр номын үүдний зүйлийг бясалгалдаа оруулбал энэ нь яг телевиз дотор зургийн аппаратны сэлбэг тавьсантай адил, тэгвэл телевизор тэр дороо эвдэрчихнэ. Ийм л утгатай юм. Нэг л холиод бясалгачихвал гон дорхноо замбараагүй болчихно, дээш бясалгаж чадахгүй болно. Үнэн худлыг нь ялгахад хэцүү, хэрвээ гажуу, хуурамч зүйлийг оруулчихвал чиний бясалгал талаар болно. Зан чанар чинь хэвийн бус байвал Багш нь ч гэсэн тусалж чадахгүй.

Гон гарах, хувирах явц маш нарийн байдаг, гэхдээ хүмүүс энэ бүхнийг энгийн хүний онолтой адил үздэг. “Би Христийн шашны зүйлээс, Буддын шашныхаас, Бумбын шашнаас, бас Күнзийн шашны зүйлээс бүгдээс нь жоохон сурья”, үүнийг олон шашин нэг гэрт орох гэнэ. Үнэндээ энэ бол утга учиргүй зүйл. Энэ бол номын төгсөлтийн үед гарч ирсэн хамгийн том асуудал юм. Хүн болгонд Буддын мөн чанар оршдог, бясалгах бодолтой, сайн хүн болох хүсэлтэй. Гэхдээ хүмүүс үүнийг энгийн хүний онолоор авч үздэг. Энгийн хүний олон талын мэдлэгтэй байвал магадгүй сайн байх. Гэхдээ бясалгагч хүнд энэ нь жинхэнэ замбараагүйтэлд хүргэнэ, түүнд бясалгах ямар ч аргагүй болно, ямар ч гон гарахгүй.

## Буддын мөн чанар

Хүнд ямар нэгэн үзэл бодол суусны дараа, тэр нь түүний амьдралд нөлөөлж болно, хүний бодлыг удирдана, тэр ч байтугай түүний баярлах, уурлах, гашуудах, цэнгэхэд бас нөлөөлдөг. Энэ бол төрсний дараа үүсдэг. Хэрвээ энэ байдал удаан хугацаанд үргэлжилбэл хүний бодолтой холбоотой болно, хувь хүний жинхэнэ бодолд шингэж хүний зан чанарыг бий болгодог.

Тэр бий болсон үзэл бодол нь хүний амьдралыг хязгаарлана, чиглүүлнэ. Хүний үзэл бодол нь ихэвчлэн амиа хичээсэн байдаг, түүнээс ч бүр муу байдаг, ингэж бодлын нүгэл үүсдэг, энэ нь хүнийг захирдаг. Хүн Эзэн бодлоор удирдагддаг (Жу юаньшэн), Эзэн бодлоо сулруулж үзэл бодолдоо давамгайлагдвал, чи үг дуугүй бууж өгсөн болно, амь чинь эдгээр зүйлд захирагдах болно.

Чи бол өөрөө төрөлх бодгаль хүн, өөрчлөгдөхгүй. Гэхдээ хүн юмыг таньж хүлээн авахад үзэл бодол амархан бий болдог, энэ үзэл бодол бол чи биш. Хүн ямар ч үзэл бодол гаргахгүйгээр асуудлыг шийдвэл бүхнийг өөрийнхөө нинжин мөн чанараар хүлээж авна, жинхэнэ өөрийн төрөлх үзлээр шийднэ, асуудалд энэрэнгүйгээр хандана. Чи өөрийнхээ төрөлх мөн чанараа их гаргах тусам чиний бодлын түвшин улам өндөр, улам үнэнд ойрхон, чи улам төрөлх нинжин байдалдаа орно. Хүний биеийг бүрдүүлэгч материйн ширхэгүүд нь маш микро түвшинд оршдог бөгөөд энэ нь хүний мөн чанарыг бүрдүүлдэг, энэ нь өөрчлөгддөггүй. Үзэл бодлынхоо хүлээснээс ангижирвал хүний нинжин чанар, ёс суртахуун, төрх, онцлог нь амархан илэрч гардаг, тэр бол жинхэнэ чи өөрөө юм.

Хүнд үүссэн үзэл бодлоос болж Эзэн бодол өөрчлөгдөхгүй. Эзэн бодлын мөн чанар үзэл бодлийн нөлөөнөөс болж өөрчлөгдөхгүй. Хүний мөн чанар нуугдмал байж болно, янз бүрийн үзэл бодолд дарагдсан эсвэл бүхэлдээ янз бүрийн нүглээр хучигдсан байж болно, иймээс илэрч гардаггүй, гэхдээ тэр өөрчлөгдөхгүй. Яагаад гэвэл нүгэлд тийм нарийн ширхэгтэй бичил матери байдаггүй. Нүгэл бол хүний орчлонд бий болдог, дэлхийн материас тогтдог учраас ширхэг нь тийм микро бичил хэмжээнд хүрч чадахгүй. Хүний амьны эх сурвалжийг бүрдүүлсэн бодисын ширхэг нь туйлын жижиг хэмжээтэй учраас нүгэл нэвтрэн орж чаддаггүй, хүний мөн чанар тэнд булаастай байдаг. Төрөлхийн мөн чанар нь юмсыг өөрийнхөө үзлээр хардаг. Хэрвээ чи олж авсан үзэл бодлоо үндсээр нь авч хаяж төрөлхийн үзэл бодлоороо байвал чи ирсэн газартаа буцаж чадна. Чиний төрөлхийн үзэл бодол бол тэр газрын үзэл бодол, тэнд чи анх бий болсон. Гэхдээ энэ олж авсан үзэл бодлоосоо салахад тун хэцүү, яагаад гэвэл энэ бол бясалгал.

Ном өөр өөр түвшинд өөр өөрөөр илэрдэг. Тухайн түвшинд тэр түвшин дэх илрэл нь байдаг. Чи тэр түвшинд бий болсон болохоор чиний үзэл бодол тэр

түвшний Номонд нийцдэг. Чиний төрөлх мөн чанар илрэхэд тэнд чиний юмыг тунгаан таних шалгуур оршдог, энэ шалгуур бол жинхэнэ чи өөрөө юм.

Нүгэлд Үнэн, Нинжин, Тэвчээр гэсэн шалгуур байхгүй, энэ нь тухайн бий болсон цаг үеийнхээ шалгуураар юмыг цэгнэдэг. Энэ нь хүнийг магадгүй энгийн хүний ярьдгаар овжин, эсвэл хашир болгодог. Ийм шалтгаанаас болж бясалгалын явцад гарсан янз бүрийн бодлын нүгэл нь бясалгахад саад болдог. Хэрэв нүглийн саад байхгүй бол бясалгахад ёстой амархан. Ийм нүгэл урьдний хэдэн жилүүдэд зарим нөхцөл, ёс суртахууны шалгуураас үүдэн гарсан, тэгээд энэ шалгуураар юмсыг цэгнэдэг. Хэрвээ энэ зүйл их хуримтлагдвал хүнийг бүх насаар нь удирддаг. Ямар нэг зүйлийг сайн эсвэл муу гэж үзэх бодол бий болоход хүн түүнд бас итгэчихдэг, мөн тэр дагуу хийх хэрэгтэй гэж боддог. Ингэхэд жинхэнэ өөрийн бодол байхгүй болдог, тэр үүссэн нинжин бус үзэл бодолдоо ороогддог, хучигдчихдаг. Тэр хүн сайн мууг цэгнэх төрөлхийн жинхэнэ шалгуураа алддаг.

Үзэл бодол тархины бодолд үүсдэг. Үзэл бодлоос гарах бодлын нүгэл нь хүний толгойн дээр нүглийн оронг үүсгэдэг. Сайн бодол гэж юу вэ? Шагжамүни бодол нэг гарахад л нүгэл болдог гэж заасан. Үнэндээ сайн бодлыг бүр дээд шалгуураар, Үнэн, Нинжин, Тэвчээр гэсэн бүр өндөр мөн чанар дагуу цэгнэвэл тэр сайн бодол гэж үзсэн нь өөр болдог.

Өөрөөр хэлбэл энэ хорвоод амьдарч байгаа энгийн хүн өөрийгөө олж чадахгүй, энэ үзэл бодол нь хүнийг зөвхөн нэг насанд нь удирдаад зогсохгүй цааш үргэлжилдэг. Хэзээ нэг цагт өөрчлөлт гарвал тэр нь арилна. Эс бөгөөс тэр үргэлж удирдсан хэвээр байна. Энэ олж авсан үзэл бодол нь улам хүчтэй болоход хүн өөрийгөө улам алдана. Одоо нүгэл дээр нүгэл нэмэгдэх гэж ярьдаг, ийм их хэмжээнд хүртлээ овоорсон. Чи энгийн хүмүүсийг хардаа, тэд өдөр болгон юу хийж байгаа, юуны төлөө амьдарч байгаагаа ч мэдэхгүй.

Хүн бүрийн төрөлхийн суурь нь өөр, ухамсар нь өөр байдаг. Үүнийг л хэлж байгаа юм. Зарим хүн үүнийг ухамсарлаж чаддаг, өөрөөр хэлбэл түүнд Буддын мөн чанар гарсан, түүнд найдвар байна. Зарим хүн ухамсарлаж чаддаггүй, учир нь олж авсан үзэл бодолдоо хэт автсан, ийм хүнд ямар ч найдвар байхгүй.

## **Бумбыг бясалгаагүй мөртлөө Бумбад байх**

Яагаад бясалгал гэж нэрлэсэн бэ? Энэ нь өөрийгээ бясалгах хөгжүүлэх арга, дээшлэх зам. Урьд нь ийм нэг үг байсан: “Энэ хүн Бумбыг бясалгадаггүй мөртлөө Бумбад байна.” Бумбын жижиг замын мөр хөөж яваа хүнээр яривал, тэр хүн үл оршихуй, хоосон зарчмыг барьдаг, амьдралдаа хувь тавилангаа дагадаг, хэрүүл тэмцлээс ангид байдаг. Тэр, “Хэрэв энэ зүйл минийх бол надад өг, биш бол би авахгүй” гэдэг зарчимтай. Тэр бясалгалын жирийн хэлбэрээр ч явдаггүй, бясалгал гэж юу болохыг ч мэдэхгүй. Гэхдээ ийм хүнийг харж ханддаг багш байдаг. Тийм хүн, хүмүүстэй бараг зөрчил үүсгэдэггүй. Үүнийг урьд “Бумбыг бясалгадаггүй мөртлөө Бумбад байх” гэдэг байсан. Жирийн хүн бас юуг ч хүсэхгүй байж чаддаг, гэхдээ эцэст нь бүтээлийн оронд хүрч чадахгүй, гон олж авч чадахгүй. Тэр зөвхөн өөрийнхөө буянг хэмжээлшгүй нэмж чадна, их буян хураана. Сайн хүн байх маш хэцүү, маш олон хүн түүнийг хохирооно гэхдээ түүнд муу юм их хийх тусам түүний буян нэмэгдэнэ. Хэрвээ бясалгах бодолтой байвал мэдээж өөрийн буянг маш их гон болгон хувиргаж чадна. Харин бясалгах хүсэлгүй бол хойд насандаа их хувь заяа хүртэнэ, том дарга болно эсвэл их баян болно. Мэдээж ихэнх эдгээр Бумбыг бясалгаагүй мөртлөө Бумбад байдаг хүмүүс бүгд их онцгой гаралтай байдаг, түүнийг хамаарах хүн байдаг. Тэр Бумбыг бясалгаагүй, гэхдээ түүний бодол, үзэл санаа Бумбад байдаг, тэгвэл тэр ирээдүйд ирсэн эх газар луугаа буцна. Бумбыг бясалгаагүй ч гэсэн тэр аль хэдийн тэнд хүрсэн, түүнд гон хувиргаж өгдөг хүн байдаг, гэхдээ тэр өөрөө мэдэхгүй. Түүний амьдрал гай зовлонгоор дүүрэн байдаг, гашуун зовлон амсаж нүглээ хариулдаг. Түүний зан чанар амьдралынх нь явцад нэг мэдэхэд дээшилсэн байдаг, үргэлж ийм байдалд байдаг. Ийм хүн их онцгой гарал үүсэлтэй байдаг. Энгийн хүн ийм байдалд байх маш хэцүү.

Күнз хүмүүнд яаж хүн жудагтай байх ёсыг үлдээсэн. Лаози бясалгалын аргыг ярьсан. Үнэндээ Хятад хүмүүс Күнзийн үзэл санааг Бумбын номтой хооронд нь хольсон юм. Сон хаант төрийн үеэс Буддын үзэл санаа дээр нь нэмэгдсэн. Улмаар Буддын үзэл санаа ч бас танигдахын аргагүй болтлоо өөрчлөгдсөн. Сон хаант төрийн дараа Буддын шашинд Хятадын Күнзийн шашны зүйл орж ирсэн, эцэг эхээ ачлах гэх мэтийн олон зүйлс орж ирсэн. Буддизмд ийм зүйлс байдаггүй. Буддизмд энгийн хүний асуудлыг хөнгөн авч үздэг, мөн энэ дэлхийд амьдарч байгаа хүн урьдын амьдралууддаа хэр их олон эцэг эхтэй байснаа мэддэггүй гэдэг. Чи хэзээ энэ олон автсан сэтгэлээсээ салж амгалан бясалгаж чадваас бясалгал чинь үр дүнд хүрнэ. Тэр бүгд бол зууралдсан сэтгэл. Күнзийн сургааль орж ирсний дараа гэр бүлийнхэндээ зууралдах сэтгэл гарч ирсэн.

## Хүнийг шавраар бүтээсэн түүх

Хүн хамгийн энэ доод давхаргад байдаг, үүнээс дээш давхарга давхаргаар тэнгэрс оршдог. Татагата (Рулай) түвшин байдаг, Есүс энэ түвшинд харъяалагддаг, мөн Лаози бас энэ Татагата түвшинд байсан. Тэдний тухайн түвшиндөө харж чаддаг байсан зүйлс нь зөвхөн тэр түвшин юмуу эсвэл түүнээс доош түвшингүүд юм. Тэд байгаа түвшнөөсөө дээшхи зөвхөн багахан зүйлсийг харж чаддаг байсан бүр дээд түвшний зүйлсийг огт харж чаддаггүй байсан. Яагаад гэвэл билгүүн чадвар хэр байх нь байгаа түвшнөөс шалтгаалдаг.

Тэгвэл Есүс, хүнийг шавраар бүтээсэн гэж хэлсэн нь түүний тэнгэрийн эзнээ гэж үздэг байсан бурхнаасаа сонссон “Бурхан хүнийг шавраар бүтээсэн” гэж дүрслэн хэлсэн үг юм. Тэр энгийн хүний мэддэг шаврыг хэлсэн үү? Үгүй, энгийн хүний шавар биш. Дээд давхаргын орон зайн бүх материал, шавар ч мөн адил бүгд бүр бичил түвшний дээд энергийн материалаас тогтсон биетүүд юм. Түүний ярьж байсан хүн хэзээ бүтээгдсэн бэ? Тэр удаагийн дэлхийн соёл иргэншлээс өмнөх үед бүтээгдсэн үү эсвэл өөр хэзээ нэгэн цагт уу? Үнэндээ энэ бол өнө эртний үеийн домог яриа, “Бурхан хүнийг шавраар бүтээсэн” гэдгийг хүмүүст ярьсан юм.

Үнэндээ бидний энэ ертөнцийн шавар биш. Нөгөө ертөнцийн шавар увьдас чадвартай байдаг, тэндээс авчирсан юм бүхэн гонтой адилхан зүйл юм. Түүний үгний утга нь нөгөө ертөнцөд бүтээгдсэн хүнийг хэлсэн. Тэнгэрийн хүний арьс энэ дэлхийн хүнийхээс илүү булбарай байдаг, яагаад гэвэл бидний энэ давхаргын бие бодийнх шиг эд эс байхгүй, илүү бичил ширхэгтэй эд эсээс тогтдог. Тэд энгийн хүний энэ орон зайд орж ирэхэд жирийн хүнтэй адилхан харагддаг гэхдээ илүү хөөрхөн, булбарай арьстай байдаг. Энэ нь хүний биед илүү том давхаргын бие бодийн эс нэмэгддэг гэсэн үг. Тиймээс хүн одоогийн ийм байдалтай харагддаг.

Тэнгэрийн хүмүүс биетэй, тэд нисээд манай ертөнцөд орж ирвэл бидэнтэй адилхан харагдана. Хятадын том уулсын доогуур тэнгэрийн хүмүүсийг оршуулсан шарил байдаг, заримыг нь үхсэний дараа уулны доор оршуулсан. Гаднаас нь харахад бидэнтэй адилхан, судар номон дээр бичсэнтэй адилгүй. Есүс амьд байхдаа ямар ч ном судар үлдээгээгүй, тэр үеийн байдлаар хойд үеийн шавь нар нь ном судар гаргасан. Шагжамүни Будда бас судар ном үлдээгээгүй, Буддын судар номыг бас л шавь нар нь бичсэн. Шавь нар нь түүний үгийг сонсоод үндсэн утгыг нь, хэнд хамаатай хэлсэн болохыг нь, түүхийн ямар үеийн зүйлийг ярьсныг нь ойлгоогүй.

Тэр шавраар хүнийг бүтээсэн гэж хэлсэн. Энгийн хүн, бидний бие шавраар хийгдээгүй шүү дээ гэж бодно. Маш өндөр давхаргын шавар бидний энэ махан биенээс ч илүү сайн, дээшлэх тусам бүр сайжирна.

Доод давхаргын хүн бий болохоос өмнө нилээд өнө эртний үед дээд амь бодь хүнийг өөр орон зайд бүтээсэн. Би тэр орон зайд ямар нэгэн зүйлийг бүтээхийг хүсвэл, тэр дороо бүтээгдэнэ. Тэнгэрт хуруугаараа дүрслэн зурахад л дурын нэг зүйл бий болно, гэхдээ өөр орон зайд хийгдэнэ. Урьд хүмүүсийн тэнгэрийн давхрууд, газар дэлхий бүтсэн тухай ярьдаг байсан нь, Буддын судруудад орчлон ертөнцийг бүтээх тухай өгүүлсэн байдаг нь бүгд Буддын аугаа увьдас чадлын илрэл юм. Өөрөөр хэлбэл сайн карма, энэрэнгүй карма байна уу муу нүглийн карма байна уу бурхад үүнийг ерөнхийд нь карма (үйлийн үр) гэдэг. Будда үүнийг бий болгосон юм.

Маш өндөр чадвартай Будда тэнгэрийн орны давхаргыг нүд ирмэх зуур бүтээж чадна, Буддын түвшин өндөр байх тусам улам үзэсгэлэнтэй сайхан тэнгэрийн оронг бүтээнэ, түүнд гараа хөдөлгөх ч хэрэг байхгүй, зөвхөн амаа нээгээд л үүнийг хэлэхэд бүгд бүтнэ. Бүр өндөр түвшний Будда байвал нэг бодоход л хангалттай бүгд бий болно. Тийм учраас Рулайгаас дээд түвшний Будда энгийн хүний зүйлийг хамаарч болохгүй, яагаад гэвэл түүний бодол нэг гарахад л газар дэлхийд шууд өөрчлөлт болно. Рулай Будда ч гэсэн энд шууд хамаардаггүй, зөвхөн удирдамж өгч Бодьсадвагаар хийлгэдэг.

## **Хязгаарлагдмал орчин үеийн шинжлэх ухаан ба гүн гүнзгий бөгөөд өргөн цар хүрээтэй Буддын Ном**

Хүн төрөлхтөн Шагжамүни Буддын тараасан Номноос хүртэл Буддын Ном хэр аугаа болохыг мэдэрсэн. Гэхдээ Ном бол үнэхээр маш аугаа. Шагжамүни Буддын өөрийнхөө түвшинд ярьсан ном нь Рулай түвшний ном юм, энгийн хүн маш өндөр гэж хардаг. Урьд зөвхөн Рулайг Будда гэж нэрлэдэг байсан. Бодьсадва, Архад нар бол Буддын түвшинд хүрээгүй учраас Будда гэж хэлэгддэггүй байсан. Иймээс тэр үед Будда гэж ярихад Рулайг хэлдэг байсан. Гэхдээ Рулай бол хамгийн дээд нь биш, харин орчлон ертөнцийн хамгийн доод зэрэглэлийн Будда юм. Зөвхөн хамгийн доод зэргийн Будда энгийн хүний асуудлыг хамаарч болно, бүр том Будда хамаарч болохгүй, амаа нэг нээхэд л газар дээр өөрчлөлт гарчихна, тэгвэл сүйд болно. Тиймээс хүмүүсийн хэрэгт оролцохгүй, зөвхөн Рулай л хамаарна. Гэхдээ Рулай ч гэсэн биечлэн бас хийдэггүй, Бодьсадва хүнийг аврах гэх мэтийн зүйлийг хийдэг. Иймээс зөвхөн Рулай түвшинд хүрсэн ч маш аугаа юм.

Микро бичил түвшинд, нэг ширхэг элсэнд гурван мянган хорвоо ертөнц байдгийг тэр харсан. Шагжамүни Будда гурван мянган бичил хорвоо ертөнцийн сургаалийг айлдсан. Тэр тэнгэрийн заадас галагтик манай дэлхийтэй адил гурван

мянган гариг байдаг, тэнд бидэнтэй адил хүмүүс амьдардаг гэсэн. Үнэндээ ийм гаригууд гурван мянгаас ч олон байдаг. Тэр бас нэг ширхэг элсэнд гурван мянган хорвоо ертөнц байдаг гэсэн. Нэг ширхэг элсэнд бидний хүн төрөлхтөн оршдог шиг гурван мянган гариг ертөнц байдаг, энэ нь санаанд багтамгүй. Тэнгэрийн мэлмий нээгдэхэд юмыг томруулж харж чаддаг, тиймээс Будда маш бичил түвшний зүйлийг харж чаддаг. Тэгвэл бодоод үзье, нэг ширхэг элсэн дотор гурван мянган хорвоо ертөнц байдаг бол тэр элсний ширхэг доторхи гурван мянган хорвоо ертөнц дотор далай тэнгис, гол мөрөн байна биз дээ? Тэдгээр гол мөрний ширхэг элсэн дотор бас гурван мянган хорвоо ертөнц байна биз дээ? Шагжамүни Будда хүртэл бие бодийн эх үүсвэр жижиг хэсгийг харж чадаагүй. Тийм учраас тэр “Дотогшоо хязгаар үгүй жижиг” гэж хэлсэн, бие бодийн эх сурвалж матерь нь харагдашгүй жижиг гэсэн.

Өнөөгийн физикийн ухаанд молекул нь атомаас бүтдэг, атом нь цөм, электроноос бүтдэг гэдгийг л дөнгөж танин мэдсэн. Бүр микро хэмжээнд кварк, нейтрино байдаг. Энэ нь танин мэдсэн хязгаар нь юм, цаашаа байхгүй. Үүнээс бүр бичил түвшинд орших материйн эх үндэс нь юу вэ? Кварк, нейтрино микроскопд хүртэл харагдахгүй. Өөр багаж хэрэгслээр тэдгээрийн оршиж байгааг илрүүлсэн. Түүнээс бүр цааш орших жижиг хэсгүүдийг илрүүлэхэд хүн төрөлхтний технологийн түвшин маш доогуур байна. Хүн төрөлхтөн од гаригсийг хамгийн том биет гэж үздэг. Шагжамүни Буддын харснаар бол тийм биш. Шагжамүни Буддын харсан бол үнэхээр аугаа том байсан. Тэр од гаригсыг хамгийн том хэсэг биш гэж олж мэдсэн. Дахиад цааш харахад том хэсгүүдийн эцэс нь харагдаагүй, эцэст нь тэр “Гадагшаа хязгаар үгүй том” гэж хэлсэн. “Гадагшаа хязгаар үгүй том, дотогшоо хязгаар үгүй жижиг” гэдэг нь томын хэмжээ нь хязгааргүй, жижгийн төгсгөл нь бас харагдашгүй гэсэн үг.

Амь бодь бол маш нарийн, орчлон ертөнцийн бүтэц бас маш нарийн байдаг. Хүн төрөлхтний олж авсан мэдлэг өнөөдөр туйлдаа хүрсэн. Туйлдаа хүрсэн нь хүн төрөлхтний шинжлэх ухааны хөгжлийг хязгаарлах зүйл болсон. Нэг жишээ ярьж, их олон сайн эрдэмтэд физик, химийн салбарт маш олон онол дэвшүүлсэн. Тэдгээр онолын хүрээнд тэдний ярьсан нь зөв юм. Тэр дагуу хөгжихөд болж байна. Гэхдээ тэр зарчим нь түвшин түвшнөөр дээшилдэг. Чи тэдний онолын хүрээнээс давахад, тэдгээр нь хүнийг хязгаарлаж байгааг олж мэднэ.

Одоогийн шинжлэх ухаан бас адилхан, зарим хүн шинжлэх ухаанд нээлт хийсэн, тэр дагуу хөгжиж байвал үүнийг шинжлэх ухаанд тооцдог. Чи тэр хүрээн дотор байхад үүнийг шинжлэх ухаан гэж үзнэ. Чи тэр нээлтийн хүрээнээс давчихвал энэ нь хүн төрөлхтний хөгжлийг хязгаарлаж байгааг олж мэднэ. Мэдрэхүйд өртөхгүй, нүдэнд харагдахгүй бүхнийг үгүйсгэдэг, маш хязгаарлагдмал шинжтэй. Бидний ярьж байгаа Будда, Дао, Бурхад хүнд харагдахгүй, мэдрэгдэхгүй, тэд өөр орон зайд оршдог. Хэрвээ орчин үеийн шинжлэх ухааны аргаар тэднийг илрүүлбэл энэ нь



шинжлэх ухаанаар батлагдсан болно биз дээ? Яг тэгнэ! Гэхдээ шинжлэх ухаан аль хэдийнээс барууны онолоор явагдаж ирсэн, орчин үеийн шинжлэх ухаанаар тайлбарлаж чадахгүй зүйлийг хүлээн зөвшөөрдөггүй, бүгдийг нь шашин судлалд, шашинд хамааруулдаг.

Барууны шинжлэх ухаан туйлдаа хүрсэн. Буддын шашинд бүх зүйлс үүсэл, тогтворжилтын үе, задралын үеийг дамждаг гэдэг. Үүсэл нь бүрэлдэн бий болох үе ба тогтворжилтын үе нь тодорхой хугацаанд оршин тогтнох үе юм. Европын шинжлэх ухаан энэ онолынхоо хүрээнээс гарахгүй бол цааш хөгжиж чадахгүй. Сүүлийн үед судалж мэдсэн зүйлс нь энэ шинжлэх ухааны хүрээнээс давсан. Иймээс тэдгээрийг шашинд, шашин судлалд хамааруулдаг. Үнэндээ орчин үеийн хүний шинжлэх ухаан, технологийн тусламжтайгаар шинжлэх ухааны салбарт байхгүй зүйлийг олж мэдвэл, эсвэл одоогийн шинжлэх ухааны аргаар мэдрэхүйд өртөхгүй, нүдэнд харагдахгүй зүйлийг судалж илрүүлбэл энэ нь шинжлэх ухаан биш гэж үү? Гэхдээ шинжлэх ухааны онол нь аль хэдийнээс өөрчлөгдөшгүйгээр тогтчихсон, түүний хүрээнээс гарсан зүйлийг хүлээн зөвшөөрдөггүй, иймээс цааш хөгжих боломжгүй.

Зарим олон онол гаргасан эрдэмтдийг тухайн салбартаа нилээд амжилтанд хүрсэнд тооцдог. Ньютон, Эйнштэйн гэх мэт энгийн хүний нийгэмд их амжилтанд хүрсэн эрдэмтэд жирийн хүнийхээс маш холыг харж чадсан. Тэдний дэвшүүлсэн онол, хойч үедээ үлдээсэн зүйлс нь мэдлэгийн их үнэ цэнэтэй өв юм. Гэхдээ яаж ч судалж, яаж ч ойлгосон бүгд тэр хүрээн доторхи л зүй тогтол юм. Хойч үеийнхэн нь тэдгээр эрдэмтдийн гаргасан онолын хүрээнд судалбал хэзээ ч түүнээс давж чадахгүй, шинэ үсрэлт хийж чадахгүй.

Хэн нэгэн энэ онолын хүрээнээс давсан нээлт, бүтээл хийвэл энэ онол нь хүнийг хязгаарлаж байсныг ойлгоно, яагаад гэвэл арай өндөр давхаргад арай өндөр танин мэдэхүйн зарчим байдаг. Энэ нь бидний материйг ойлгодогтой адил, урьд хүмүүс материйг бүтээдэг хамгийн жижигхэн ширхэг элемент бол атомын цөм гэж үздэг байсан. Гэхдээ одоо хүмүүс тэгж үзэхээ больсон, бас кварк, нейтрино-г илрүүлсэн. Хүмүүс ийм байдлаар энэ талын танин мэдэхүйгээ үргэлж тэлж байдаг. Ямар нэгэн нээлт гарах бүрд шинэ онол гардаг, тэр нь бас нэгэн хязгаарлалт болдог, ингэж л явагддаг. Үнэндээ тэдгээр онол нь гол төлөв хүнийг хязгаарладаг.

Эйнштэйн энгийн хүн биш байсан, тэр шашинд, тэр ч байтугай Бурханы ном сударт заасныг зөв гэж олж мэдсэн. Хүний материаллаг ертөнцийг танин мэдэх нь хүн төрөлхтөний мэдлэгийн хүрээнд хязгаарлагддаг. Энэ нь орчин үеийн шинжлэх ухаанд гарсан хуулиудтай мөн адилхан. Хүний судалгаа шинжилгээ үнэхээр дэвшингүй болж цаашид хөгжихөд шашинд ярьдаг нь зөв гэж олж мэднэ. Иймээс арай өндөр давхаргад орших амь бодийн шинжлэх ухаан техникийн түвшин нь арай өндөр, тэдний эзэмшсэн технологи, ертөнцийн талаархи ойлголт нь энгийн хүний

танин мэдэхүйгээс давамгайл байдаг. Эйнштэйн бол хүн төрөлхтний шинжлэх ухаан технологийн танин мэдэхүйн оргилд хүрсэн хүн байсан, тэр цаашдын судалгаагаараа шашинд ярьдаг бүгд үнэн болохыг олж мэдсэн. Сүүлийн үед амжилтанд хүрсэн маш олон эрдэмтэд, гүн ухаантнууд эцэст нь бүгд шашинд итгэдэг болсон. Харин одоогийн шинжлэх ухааны хүрээнд хязгаарлагдсан, шинжлэх ухаанд сохроор итгэдэг хүмүүс энэ бүгдийг (шинжлэх ухаанаас давсан зүйлийг) хуучны мухар сүсэг гэж үздэг.

## **Бүх бясалгалын зам нь эх үндсэндээ буцах**

“Бүх бясалгалын зам нь эх үндсэндээ буцах” гэсэн үг номын үүд болгонд яригддаг. Бумбын системд гурван мянга зургаан зуун номын үүд байдаг гэдэг, бүгд Бумбад хүргэж чадна. Буддын системд наян дөрвөн мянган номын үүд байдаг гэдэг, аль ч номоор нь Будда-д бясалгаж болно. Гэхдээ энэ нь янз бүрийн шашныг цуг бясалгаж болно гэсэн үг биш, хүн яаж тэнгэрийн бүх зүйлийг мэдэж чадах юм, тэр бол ёстой замбараагүйтэл.

Эртний Хятадад, Чин хаант төрийн сүүлчийн үед гарч ирсэн “Нэгдсэн зам” (Игуандо) гэдэг бүлэг байсан, тэр нь таван шашныг нэгтгэхийг ярьдаг байсан харгис шашны бүлэг юм. Чин хаант төрийн үед үүнийг үүсэн гарахад нь устгахыг оролдсон, Чин гүрний хаан устган дарахыг чармайдаг байсан. Бүгд найрамдах засаглалын эхэн үед бас үүнийг устгаж байсан, олноор нь цаазаар авч байсан. Хувьсгалаар Коммунист нам ялсны дараа бас энэ бүлгийн гишүүдийг бөөн бөөнөөр нь буудан хороодог байсан. Яагаад ингэдэг байсан бэ? Үнэндээ энгийн хүний нийгэмд болдог бүх зүйл учиртай байдаг. Түүхийн хөгжил тэнгэрийн өөрчлөлтийн дагуу явагддаг. Тийм учраас энгийн хүний нийгэмд гардаг бүх зүйл хэн нэгний дурын хүслээр болдоггүй, өөрөөр хэлбэл үүнийг энгийн хүмүүс устган дарахыг хүссэн биш, тэнгэрийн зарлигаар болсон. Дээд амь бодь үүнийг устгахыг хүссэн, үүнийг оршихыг зөвшөөрөөгүй. “Таван шашинг нэгтгэх” гэдэг нь утгагүй зүйл, Номыг бусниулж байгаа ноцтой хэрэг. Энэ бол хүмүүсийн дунд ад чөтгөрийн хийж байгаа үймүүлэл.

Тэнгэрийн эх сурвалжийн бурхан, Шагжамүни Будда хүртэл Буддынхан, Бумбынхныг нэг дор бясалгахыг ярьж зүрхлээгүй, ингэж яаж болох юм! Буддын шашинд бас хоёргүй номын үүд гэж ярьдаг. Жишээ нь: Ариун Орны номоор бясалгавал Даяаны номын зүйл оруулж болохгүй, хоёуланг нь хольж бясалгаж болохгүй. Даяаны номоор бясалгаж байгаа хүн Тиантай юм уу эсвэл Хуаянь номын үүдний зүйлийг оруулж бясалгаж болохгүй, өөр зүйлсийг хооронд нь хольж бясалгаж болохгүй. Яагаад вэ? Яагаад гэвэл гонын хувиралт нь маш нарийн байдаг. Чи зөвхөн нэг л биетэй, хэрвээ чамайг нэг түүхий эд гэвэл энэ тоног төхөөрөмжинд

боловсрогдоно, чиний гон энэ тоног төхөөрөмжинд хувирна. Чамайг яаж аврах, алхам тутамд чинь яаж явахыг, гон болгоны хувирах хэлбэр энэ бүгдийг чамд маш нарийн зохицуулж өгдөг. Тэгвэл явц дунд нь чи өөр нэг тоног төхөөрөмжинд орвол юу болох вэ? Тэгвэл яаж бясалгах юм? Чи хэлдээ тэгвэл юу болох вэ? Чи бүхэлдээ замбараагүй болно, хаягдал материал болчихно.

Маш олон хүн бясалгаад дээшилдэггүйн учир нь бясалгалын янз бүрийн аргыг хооронд нь хольсноос болдог. Шагжамүни Будда “Хоёргүй номын үүд” гэж хэлдэг байсны үндсэн утга нь бясалгалын аргуудыг хольж бясалгаж болохгүй гэсэн үг юм. Хожим хүмүүс “Хоёргүй номын үүд” гэсний утгыг гажуудуулж өөр утгаар ойлгосон. Өөр системийн аргуудыг хольж бясалгахыг хатуу хориглоно. Харин тэр “Нэгдсэн зам” бүлгийн заасан “Таван шашингийн нэгдэл” бол тэнгэрийн хуулинд зөвшөөрөгдөхгүй зүйл. Одоо Тайванд энэ бүлэг дахин гарч ирсэн. Номын төгсгөлийн үед хэн ч үүнд оролцохгүй, яагаад гэвэл одоо хүн төрөлхтний асуудлыг хариуцах хэн ч байхгүй болсон. Хүн улам бүр доройтсоор байна, бүгд (бурхад) энэ зүйлийг хийхээ больсон, хэн ч хамаарахгүй болсон, хүнийг аврахаа ч больсон. Одоо Буддыг шүтдэг, мөргөдөг хүмүүс шантаршгүй бясалгахын төлөө биш, харин баян болох, гай зовлонгоосоо салахыг л хүсдэг болсон, ийм байдалд хүрсэн.

Хүмүүс одоо хүртэл тэр бүлгийн ярьдгийг зөв зүйтэй гэж үздэг. Бясалгагч хүнд болон шашин шүтэгч хүнд ямар бодол гарах нь маш чухал байдаг. Яагаад гэвэл зарим бясалгалын арга итгэл үнэмшилд түшиглэдэг, ямар ч арга барил байхгүй, бодолдоо өөр зүйл оруулчихвал чиний бясалгасан зүйлийг будлиантуулчихдаг. Үнэндээ ямар ч хөдөлгөөн байхгүй. Мөн одоо ад чөтгөр хүний орчлонд энд тэндгүй байна, хүн төрөлхтөнд сүйрлийг авчирч байна! Хүнд нинжин сэтгэл байдаг биз дээ? Ад чөтгөр үүнийг л устгаж чиний бясалгалыг үр дүнгүй болгодог.

## Даяаны шашны туйлшрал

Хүмүүсийг туйлширсан ба дундыг сахисан гэж хоёр хувааж болно. Даяаны шашин (Зэн Буддын шашин) анх үүсэн бий болохоосоо туйлширсан талд байсан, энэ нь бясалгалын системд тооцогддоггүй. Даяанд үеийн үед маргалдаж ирсэн. Даяаны шашны аргаар бясалгаж байсан хүмүүс ч гэсэн Буддад ариун сэтгэлийн үүднээс бясалгадаг байсан, Шагжамүни Будда тэднийг үргэлж хамаарч байсан, энэ нь бясалгалын систем болж чадаагүй. Бодьдарма өөрийн тэнгэрийн оронгүй учраас хүмүүст аврал үзүүлж чадахгүй. Бодьдарма тэр үедээ Шагжамүни Буддыг үүсгэн байгуулагч Багшаа гэж үздэг байсан. Тэр Даяаны шашны хамба гэж хэлэгддэг байсан ч Шагжамүни Буддын шавь, хорин наймдахь үеийн шавь нь байсан. Тэр Шагжамүни Буддыг их шүтэн биширдэг байсан. Шагжамүни Буддын номноос тэр гол нь “хоосон” гэдэгт төвлөрсөн, Шагжамүни Буддын онолоос гараагүй. Даяаны шашин цаашид улам доош уруудсан. Хойч үеийнхэн нь Бодьдармагийн энэ хандлагыг бие даасан бясалгалын арга гэж бодсон, түүнийг хамгийн дээд нь гэж үзсэн. Гэхдээ энэ нь хамгийн дээд нь биш. Даяаны шашин үеэс үед уруудаж байсан. Бодьдарма өөрөө ч түүний заасан ном зөвхөн зургаан үед уламжлагдана гэж хэлсэн.

Бодьдарма, Шагжамүни Буддын ярьсан “хоосон” гэх ухагдахууныг голлон анхаарсан ба Шагжамүни Буддыг их бишрэн хүндэлдэг байсан, түүний хорин наймдахь үеийн шавь гэж нэрлэгддэг байсан. Гэхдээ хойч үеийнхний хэт туйлширсан үзэл нь Даяаны шашинг уналтанд оруулсан. Тэд Бодьдарма-г бараг Шагжамүни Буддатай адилхан авч үзэн түүнийг бишрэн шүтдэг байсан. Бодьдармагийн номлолыг Буддын цорын ганц үнэн гэж үзсэн. Тэд ёстой буруу зам руу орсон.

Яагаад гэвэл Бодьдарма доод түвшинд бясалгасан. Тэр дөнгөж Архатын түвшинд хүрсэн, зөвхөн нэг Архат л байсан. Тэр хэр их зүйл мэдэж чадсан бэ? Тэглээ ч эцэст нь Рулай түвшинд хүрч чадаагүй. Түүний түвшин Шагжамүни Буддын түвшнөөс хэр хол байсан гээч! Түүний заасан нь энгийн хүний гүн ухаантай их ойролцоо, энгийн хүмүүс, ялангуяа шашныг нэг хэлбэрийн гүн ухаан, үзэл суртал гэж үздэг хүмүүс түүний номлолыг их амархан хүлээж авдаг. Буддын шашны номлолыг гүн ухааны нэг салбар болгон судалдаг хүн үүнийг илүү хүлээн зөвшөөрдөг, энгийн хүний философийн ухаантай их адилхан болсон.

Хэр их өндөр түвшинд хүрсэн ч тэнд бас л Будда байдаг. Даяаны шашнаар бол бясалгаад бясалгаад эцэст нь юу ч оршихгүй болдог. Бясалгалыг нь яривал, тэд хүний оршихуйг ч хүлээн зөвшөөрдөггүй, нүдний өмнө харагдаж байгаа амьд хүнийг ч тэд бодит гэж үздэггүй. Тэд “Би харагддаг зүйлд үнэмшинэ, харагдахгүй зүйлд үнэмшихгүй” гэдэг гэгээлэг бус энгийн хүмүүсээс ч дор, мөн бүр харагдаж байгаа зүйлийг ч хүлээн зөвшөөрдөггүй. Тэгвэл амьдрах ямар хэрэгтэй юм? Нүдээ нээж яах юм? Нүдээ аниад л хэвтэх ч хэрэггүй, зогсох ч хэрэггүй... юу ч байхгүй

юм чинь. Тэд туйлширсан юм, Бодьдарма түүний ном зөвхөн зургаан үед уламжлагдана гэж хэлсэн. Өнөөдөр хүмүүс эхнээсээ л үл орших энэ номлолд бөх бат зууралдсан хэвээр байгаа нь инээдэмтэй, тэд мухардалд орсон доош унасан. Тэд өөрийгөө ч үгүйсгэдэг, Буддыг ч үгүйсгэдэг, дэлхийг ч үгүйсгэнэ гэж үү? Хэрэв тэд өөрсдийнхөө байгааг ч үгүйсгэж байвал, нэртэй байж яах юм? Хоол идэж яах юм? Өдөр болгон хоосон яваад л, хэдэн цаг болж байгааг ч харах хэрэггүй, бүх дуу чимээг сонсох ч хэрэггүй...

Энэ бүхний эцэст юу ч байхгүй болно, энэ нь Шагжамүни Буддын нэр төрийг гутааж байгаа биш гэж үү? Шагжамүни Будда юу ч зааж уламжлаагүй гэвэл тэр дөчин есөн жил юу хийсэн болох вэ? Шагжамүни Буддын “Хоосон” гэж ярьсны жинхэнэ утгыг мэдэх үү? Бид Шагжамүни Будда Ном үлдээгээгүй гэж ярьдаг нь, жинхэнэ бясалгах арга ба орчлон ертөнцийн номыг тэр яриагүй гэж байгаа юм. Түүний ярьсан зүйл нь зөвхөн түүний бясалгасан түвшний зүйл юм, Тэр энгийн хүмүүст Рулай-н номыг үлдээсэн, ялангуяа бясалгалын турш, сургамж, сургаалийг үлдээсэн юм. Шагжамүни Будда энэ дэлхийд амьдарч байхдаа үлдээсэн ном нь бол сахил санваарь дэг юм, бас өөр өөр давхаргын танин мэдэхүйг ярьсан, энэ нь бас түүний түвшин дэх ном юм. Гэхдээ Шагжамүни Будда бусдыг өөрийнхөө түвшинд хязгаарлахгүйн тулд, “Би энэ насандаа ямар ч ном яриагүй” гэж хэлсэн. Яагаад гэвэл тэр өөрийнхөө ярьсан номыг хамгийн дээд ном биш гэдгийг мэдэж байсан. Рулай бол Будда, гэхдээ хамгийн өндөр түвшнийх биш. Буддын ном хязгааргүй. Түүний ярьсан ном бясалгагчийг хязгаарлаж болохгүй. Аугаа суурьтай хүн түүнээс өндөр түвшинд бясалгаж болно, тэр түвшний танин мэдэхүй болон Номын илрэл нь илүү өндөр бөгөөд гүн гүнзгий .

## Бясалгалын явц дахь түвшин

Зарим хүн бясалгалын явц дахь түвшнээ мэддэг, гэхдээ бясалгадаг хүн өөрийнхээ түвшнийг мэдэх хэрэгтэй гэсэн үг биш. Ихэнх бясалгагчид зөвхөн гэгээрсний дараа эсвэл Гурамсан ертөнцийн номноос дээш гарсны дараа түвшнээ мэдэж болно. Тийм хүн бясалгагчийн түвшнийг биенээс цацрах гон-ы өнгөөр нь эсвэл биен дээрх гон баганы өндрийг хараад л мэдчихдэг. Гурамсан ертөнцийн номонд бясалгаж байх үед эхний шатанд бясалгагчаас гардаг гон-ы өнгө улаан байдаг, дээшлэхэд улбар шар дараа нь шар, ногоон гэх мэт өнгөтэй болдог, нийт есөн өнгө гардаг: улаан, улбар шар, шар, ногоон, хөх, цэнхэр, ягаан, өнгөт, өнгөгүй. Чамайг ямар түвшинд байгааг хэлэхэд нэг харахад л хангалттай. Тунгалаг биетэй болсны дараа үргэлжлэн дээш бясалгавал Гурамсан ертөнцийн номноос гарч байгаа юм. Бүтээлийн оронд хүрнэ, Архатын номын эхний шатанд хүрч байгаа юм. Гурамсан ертөнцийн номоор бясалгаж Гурамсан ертөнцөөс гарвал энгийн хүний дахин төрөл олох замын тойрогт дахин орохгүй болно. Хэрвээ энд хүрээд бясалгалаа дуусгавал тэр Архат болно. Дахиад дээшээ бясалгавал дээд давхаргын Архатад хүрнэ, бас өнгөөр ялгагдана. Гэхдээ тэр улаан, улбар шар, шар, ногоон, хөх, цэнхэр, ягаан өнгөнүүд нь Гурамсан ертөнцийн номын үед гардаг нягт, энгийн хүмүүсийнх шиг өнгөнөөс ялгаатай. Энэ түвшний өнгөнүүд: улаан, улбар шар, шар, ногоон, хөх, цэнхэр, ягаан, цагаан, өнгөгүй-тунгалаг болдог. Бүр дээш бясалгахад бас л есөн төрлийн өнгөтэй байдаг, улам тунгалаг, улам сийрэг, улам өнгөлөг байдаг. Ийм янзаар эдгээр өнгө нь дахин дахин давтагдана. Иймээс хүний аль түвшинд бясалгаж хүрснийг нь хараад л мэдчихдэг.

Гэхдээ хүнд харуулахгүй, энгийн хүнд үүнийг ил тод харахыг зөвшөөрөхгүй, яагаад гэвэл үүнд ухамсрын асуудал байдаг. Хүний бясалгалаар гардаг зүйлс бүгд биеийн гадна илэрвэл юуг нь ухамсарлах юм? Тэгвэл хүн болгон бясалгана, хэн ч үүнийг хүснэ, ийм байхад сурахыг хүсэхгүй хүн байх уу? Бүх үнэн харагдана. Арван хар нүгэл хийсэн хүн ч, уучлашгүй нүгэлтэй янз бүрийн муу хүмүүс ч ирж сурна. Ухамсарын асуудал гэж байхгүй болчихно, тэгвэл бясалгал хийх арга байхгүй. Зарим хүн ингэж ярьдаг, “Миний нүдэнд бүх зүйл тодорхой харагдвал би сурна.” Тэгж болохгүй. Хэрвээ энэ хүн юм болгоныг тов тодорхой харж чадвал цаашид бясалгах аргагүй болно. Түүнд бясалгахыг зөвшөөрөхгүй. Яагаад гэвэл хүн төөрөгдлийн дунд байж ухамсарлах ёстой, зөвхөн тэгвэл бясалгал гэж тооцогдоно. Хүн зуун хувь гэгээрч юм болгоныг харж чаддаг болбол тэр хүн бясалгаж чадахгүй болно. Яагаад вэ? Яагаад гэвэл энэ нь бясалгасанд тооцогдохгүй, бүх үнэнг харчихна. Хүн хүний хооронд гардаг зөрчил учир тавилангийн холбоотой болохыг харна, хүнийг доромжилж дээрэлхсэн хүн дээрэлхүүлсэн хүнд буянаа өгдгийг тэр харна. Үнэн байдлыг бүгдийг харсан хүн мэдээж бясалгана. Энэ нь бясалгалд тооцогдох юм уу? Энэ нь юмыг зүгээр авсантай адил. Ийм замаар энгийн хүний сэтгэлээс салж чадахгүй.

Зөрчлийн дунд энгийн хүний сэтгэлийг орхих ёстойг хүн өөрөө ухамсарлах ёстой. Хэрэв тэр бүгдийг тов тодорхой харчихвал үүнийг бясалгал гэж хэлж болохгүй. Будда-д түвшнөө ахиулахад яагаад хэцүү байдаг вэ? Яагаад гэвэл түүнд бусадтай зөрчил байхгүй, тэр бүгдийг тов тодорхой хардаг, тэр яаж бясалгах юм? Бясалгах нь хамгаас хэцүү, тиймээс тэд энгийн хүний дунд ирж бясалгах хүсэлтэй. Зөвхөн төөрөлтийн дунд бясалгахад хурдан дээшилдэг. Бясалгалын явцад зарим хүнд багахан зүйл харагдаж болно. Гэхдээ мэдээж нарийн зүйлсийг хүнд харуулахгүй.

Хүн бясалгалынхаа эхнээс эцэс хүртлээ төөрөлтийн дунд бясалгана, энэ туршид ухамсарлах асуудал тавигддаг. Барууны орнуудад итгэл үнэмшилд их ач холбогдол өгдөг, эхлэхээс авхуулаад төгсгөл хүртэл итгэлийг ярьдаг, итгэхгүй бол юу ч олж авахгүй. Чамд итгэл байвал хариу ирнэ. Зарим хүн Есүсийн хөрөгний өмнө нүглээ наминчлахад, Есүс түүнийг сонсч байгаа мэт санагддаг, үнэхээр хэн нэгэн түүний асуултанд хариулж байгаа мэт байдаг. Барууны бясалгалын арга ийм л байдаг. Шашин шүтэх нь бас бясалгалын нэг хэлбэр. Есүс сүсэгтнүүдээ тэнгэрийн орондоо хүлээж авахад бэлэн байсан, гэхдээ хүний биенд гон энерги байхгүй бол тэнгэрийн оронд очиж чадахгүй. Мөн энгийн хүний нийгэмд олж авсан муу бодол санаатай, биендээ их нүгэл тээж дээд түвшинд очихыг орчлон ертөнцийн мөн чанар хориглоно. Маш муу хүний бие, сүнс нь устана, юу ч байхгүй болно. Энэ ямар аюултай вэ? Гон байхгүй бол ёстой болохгүй. Хүн итгэл үнэмшилтэй байж, өөрийн нүглээ наминчлан сайн хүн болохын төлөө байнга өөрийгөө дээшлүүлж байвал нөгөө талд түүнд гон хувиргаж өгдөг. Түүний гон өсч байсан ч өөрт нь мэдүүлдэггүй, тэдэнд зөвхөн сайн хүн байхыг л хэлдэг, гон-ы талаар ярьдаггүй. Буддын лам хуврагууд бас адилхан, тэд дасгал хийдэггүй, тэдэнд гон яаж өсдөг вэ? Гон нь өсч байсан ч тэдэнд хэлдэггүй.

## Будда ба Бумба

Бумбын системд ганцаарчлан даяанчлан сууж бясалгадаг, Бумбын шашин уг нь байх ёсгүй. Бумбын шашин бол сүүлийн үед гарсан өөрчлөлтийн бүтээл. Түүхийн өмнөх бүх иргэншилд Бумбын шашин байгаагүй. Яагаад гэвэл Бумбын системд бүх амийг аврахыг ярьдаггүй, харин ганцаарчлан нам гүмд бясалгадаг. Иймээс Бумбын бясалгагч үнэнг ухамсарлахын төлөө явдаг, Үнэн Нинжин Тэвчээрээр дээшлэхдээ гол нь үнэний эрэлд бясалгадаг, шударга үнэнийг эрхэмлэдэг, бясалгаж ёс суртахуун, зан чанараа дээшлүүлнэ, амьны эх үүсэлдээ буцах, үнэний гэгээрэлд хүрэхийг эрмэлздэг. Бумбад тайван бясалгахыг номлодог, иймээс бүх амийг өргөн хүрээнд аврах хүсэл байхгүй. Бясалгаж үр дүнд хүрсний дараа тэр хаа сайгүй аялагч чөлөөт бурхан. Тэнгэрт бас энд байдаг шиг уул ус байдаг, тэр тэнгэрийн аль нэг ууланд очиж байрладаг. Үнэндээ Бумбын шашин үүссэний шалтгаан бол энгийн хүмүүстэй зууралдсан сэтгэлээс болсон юм. Хүмүүс хамтдаа бөөгнөрч хүчээ нэгтгэх дуртай, хүн болгонд нэр хүнд, хувийн ашиг сонирхол байдаг, иймээс эдгээр зүйлс амархан гардаг.

Үнэндээ Бумбын шашин байдаггүй. Бумбынхан шавьдаа ганцаарчлан заадаг. Бумбын шашин үүсч олон шавьтай болсон ч бүгдэд нь жинхэнэ уламжилдаггүй. Багш нь тэдний дундаас хамгийн шилдэг шавийг сонгож уламжилдаг, сайн шавь олдохгүй бол өөрийн тааваар хийх дуртай зүйлээ хийдэг. Тэр Бумбад хүрсэн учраас чөлөөт аз жаргалыг эдэлнэ.

Буддынх бол Буддынх, Бумбынх бол Бумбынх. Энэ хоёр системийн номлолыг нэгтгэх ямар ч боломжгүй. Харин бидний бясалгаж байгаа бол үнэхээр маш аугаа. Бид орчлон ертөнцийн мөн чанар дагуу бясалгадаг, үүнд бүх зүйл багтдаг. Бид Буддын системд суурилдаг, манай бясалгалын үндсэн онол, онцлог нь Буддынх. Гэхдээ энэ ном Буддын болон Бумбын номноос давж гарсан юм. Өөр өөр түвшинд өөр өөр танин мэдэхүй байдаг, өөр өөр түвшинд өөр өөрөөр илэрдэг. Фалунь тэнгэрийн оронд түүний өөрийн гэсэн танин мэдэхүй байдаг, Фалунь орноос дээш бүр дээд танин мэдэхүй оршдог, түүнээс дээшилбэл бас түүнээс дээд танин мэдэхүй оршино.

Эртний анхдагч бурхдын түвшин гэж байдаг. Одоогийн бясалгагч нарт энэ талаар ярих шаардлагагүй, ухаан санаанд нь багтахгүй, тэр түвшинд хүрч чадахгүй. Иймээс бид зөвхөн Буддын ба Бумбын хоёр системийг л ярина. Хэт дээд түвшний зүйл яривал болохгүй, хүмүүс хүлээн авч чадахгүй, үүнийг мэдэхийг ч зөвшөөрөхгүй.



## Ном заах, хүн аврахад үзүүлбэр байхгүй

Энгийн хүн шиг бясалгаж байгаа лам хуврагт жинхэнэ Номыг яриад нэмэргүй, гэгээрлийн хутагт хүрээгүй лам хувраг ч мөн адил юу ч мэдэхгүй. Мөн тэдгээр гэгээрсэн лам хуврагууд хүмүүсийн дунд байхгүй, бүгд уул хөвчийг бараадсан. Тэд бүгд намайг мэддэг, зөвхөн энгийн хүмүүс мэдэхгүй. Дээд түвшинд хүрсэн олон бясалгагчид намайг мэддэг, тэд заримдаа сэмээрхэн ирж намайг харж байгаад явчихдаг. Зарим нь ирж жоохон юм ярьж байгаад явдаг. Тэд алсын уулс, ой хөвчид хэдэн зуун жил, хэдэн мянган жилээр бясалгасан ч тэдний түвшин өндөр биш. Яагаад гэвэл тэдний явж байгаа зам нь маш хэцүү, аугаа замаар бясалгаагүй, зөвхөн жижиг замаар бясалгаж байгаа учраас хэдий их урт хугацаанд бясалгасан ч жинхэнэ үр дүнд хүрч чадаагүй. Тэд энгийн хүний нийгэмд ирдэггүй учраас гон чадвар нь түгжигддэггүй, өөрийн ер бусын чадвараа хэрэглэж болдог. Харин энгийн хүний нийгэмд бясалгахад хүчирхэг ер бусын чадварууд түгжигддэг, нэг бодол гарахад л байшинг өөр газар шилжүүлчихнэ, тийм зүйл байж болохгүй. Энгийн хүний нийгмийн байдлыг сүйтгэхийг туйлаас зөвшөөрөхгүй. Хүмүүс тийм хүний түвшинг өндөр гэж бодно. Энгийн хүний нүдэнд ер бусын чадвараа үзүүлсэн хүн болгон аугаа. Нийтийн дунд хийдэг тэдгээр чигон багш нарын үзүүлбэр бол бүгд жижиг ер бусын чадвар, арга увидасын зүйлүүд, маш өчүүхэн төдий зүйл, юу ч биш. Гэхдээ энгийн хүмүүс үүнийг маш өндөр түвшний зүйл гэж боддог.

Би Ном заан тараахдаа ямар нэгэн үзүүлбэр хийхээс татгалздаг учир нь би гарч ирсэн зорилгоо та бүхэнд маш тодорхой ярьсан. Хэрвээ би Номоо заан тараахдаа үзүүлбэр хийвэл буруу номын замаар заасан болно. Тэгвэл хүмүүс чиний арга увьдасыг сурахаар ирнэ, номонд сурахаар ирэхгүй. Шагжамүни Будда тэр үедээ бас үүнээс зайлсхийдэг байсан. Өвчнийг эдгээж болно, чамд харагдахгүй учраас зөвхөн сайжирснаа л мэдэрнэ. Яаж эдгээсэн бэ? Итгэх итгэхгүй нь чиний өөрийн хэрэг. Өвчтөн эдгээрсэн, үүнд үнэмших үү? Түүний өвчин байсаар байгаа юу, үгүй юу гэдгийг хөндлөнгийн хүн мэдэхгүй. Үүнд итгэл үнэмшлээс өөр зүйл байхгүй. Тиймээс өвчнийг эдгээж өгч болно. Есүс болон Шагжамүни Будда тэр үедээ бас хийсэн. Зөвхөн Лаози үүнийг хийгээгүй, тэр хүний ертөнцийг тун аюултай болохыг мэдсэн. Санд мэнд таван мянган үгт судраа үлдээгээд Барууныг зорьсон.

Хүн төрөлхтний нийгэм маш ээдрээтэй, дэлхий дээр байгаа хүн аль ч орон зайнаас ирсэн байж болно, тэр орон зайн бурхан түүнийг хариуцах сэтгэл нь хэвээр. Энэ нь түүний ухамсраас хамаарна, хэрэв тэр ухамсарлаж чадвал буцаж чадна. Гэхдээ тэр бурхан энэ хүнийг нэмэргүй муу болсныг мэднэ, түүнд юу ч хийж чадахгүй. Гэхдээ түүнийг орхихыг бас хүсэхгүй. Есүс хүнийг аврахаар ирсэн тэр үед түүнийг тэдний хэрэгт дундуур нь оролцож байна гэж үзсэн. “Энэ хүн минийх, тэр миний энд аврагдах ёстой, чи яагаад бидний хэрэгт оролцож байгаа юм?” Тэд үүнийг хүлээн зөвшөөрөөгүй. Тэдний хийсэн нь ийм сэтгэлээс болсон юм, үүнийг

бодож үзвэл зөв биш. Есүс-д хэн хаана хамаатай байх нь чухал биш байсан, түүний ирсэн зорилго нь хүнийг аврах юм, бүх амь зовлонтой байгааг тэр харсан, тэдэнд аврал үзүүлэх, хүмүүст дээшлэх боломж өгөхийг хүссэн. Тиймээс Есүс маш олон орон зайн бурхдад нөлөөлсөн. Эцэст нь тэдний зөрчил их ширүүсч хүний орчлонд илэрсэн. Хүмүүс хоорондын хурц зөрчлийн адил хэмжээнд хүрч бүх цохилт Есүс дээр буусан. Есүс үүнээс өөрийгээ гаргаж чадаагүй, зөвхөн үхэхээс өөр арга байгаагүй, тиймээс цовдлогдож тэдний заналыг тайлсан. Энгийн махан биеэ орхисон учраас түүнд хийх занал төгсгөл болж тэр хэмжээлшгүй хүнд зовлонгоос ангижирсан. Иймээс Есүс бүх амийн төлөө амиа өгсөн гэдгийн утга нь ийм л юм.

Шагжамүни Будда номоо тараахдаа бас их зовсон, тэр Энэтхэгийн долоон янзын шашинтай тэмцэж байсан. Тэр үед эртний Брахман шашин маш хүчтэй байсан. Эцэст нь, Шагжамүни Будда жинхэнэ хүрэх зорилгодоо хүрч чадалгүй явсан.

Лаози “Таван мянган үг” бичиж хойч үеийнхэндээ гэрээслэл болгон үлдээгээд явсан. Тэр хийх ёстой зүйлээ л хийсэн, энэ бас тэнгэрийн шийдвэр юм. Бумбад шашин бий болгохыг зөвшөөрдөггүй, Бумбын шашин үүссэн нь алдаа байсан. Бумбад ганцаарчлан бясалгахыг номлодог, үнэнд бясалгах, тайван бясалгалыг эрхэмлэдэг учраас нэг л шавьд уламжлан заадаг. Уламжлан заахын тулд ганц сайн шавийг сонгох ёстой. Тэр бүх амьд аврал үзүүлнэ гэж ярьдаггүй, тийм хүсэл байхгүй, тэр үнэнг бясалгадаг. Бумбын сүм хийдэд олон шавь байхыг харсан байх, гэхдээ зөвхөн нэг л шавийг сонгож уламжилдаг, бусад үлдсэн нь зүгээр л байгаа юм. Иймээс Бумбад шашин байх ёсгүй. Урьд нь тэд үргэлж ууланд ганцаар бясалгадаг байсан.

Күнзийн заасан нь бясалгал биш, харин хүний ёс. Гэхдээ түүний сургааль нь Хятад хүмүүст их ач тус үзүүлсэн. Түүний “Дундаж үзэл” нь хүнийг ялагдашгүй байдалд хүргэж чадна. Яагаад гэвэл юмс үзэгдэл туйлдаа хүрээд эсрэгээр өөрчлөгдөж буцдаг. Өөрөөр хэлбэл оройдоо хүрээд буцаад доош унаж болно, “Дунд”-ыг сахигч хэзээд дундыг л барьдаг. Ийм байдлаар өндөрт гарахгүй ч доош унахгүй, хэзээд ялагдашгүй байдалд байна. Аливаа зүйл туйлширвал эсрэгээр эргэдэг. Энэ нь энгийн хүнд хамаатай юм.

Алсын ууланд, ой хөвчид бясалгадаг хүн олон байдаг. Тэд түүхэнд болж өнгөрсөн үйл явдлыг болон ирээдүйд болох үйл явдлыг бүгдийг мэддэг, гэхдээ хэн ч үүнд оролцохгүй, оролцохыг ч хүсдэггүй. Тэд энэ бүгд тэнгэрийн өөрчлөлтөөс болж гардаг, ийм л байх ёстой гэдгийг мэддэг.

Тэнгэрийн зарлигийг зөрчсөн хэн боловч шийтгэл хүлээнэ, хэн ч тэгж зүрхлэхгүй. Хүн болгон Юэфэй-г аугаа хүн гэж магтан дуулдаг байсан, гэхдээ Юэфэй яагаад Өмнөд Сон хаант төрийг хамгаалж чадаагүй вэ? Юэфэй-гийн удам угсаа хүчтэй байсан биз дээ? Энэ нь ийм л тэнгэрийн таалал байсан. Юуфэй Сон

хаант төрийг унагаахгүйн төлөө үнэхээр зүтгэсэн боловч чадаагүй, яагаад гэвэл тэр тэнгэрийн тааллын эсрэг юм хийсэн. Сон хаант төр устгах тавилантай байсан, харин тэр үүний эсрэг явсан учраас тэнгэрийн тааллыг зөрчсөн. Энэ утгыг л ярьж байгаа юм. Хүн яаж төлөвлөсөн ч тэнгэрийн таалалтай харьцуулшгүй. Юэфэйг муу хүн байсан гэж хэлээгүй, зөвхөн энэ зарчмыг л тайлбарлаж байна.

Хүн, энгийн хүний талаас харахад зөв зүйл нь магадгүй зөв биш. Чин хаант төрийн эхний хаан эсвэл Хан гүрний хаан Ву, ямар ч хаан байсан тэдний хийсэн зүйлийг хойч үеийнхэн нь өөрийнхөөрөө дүгнэдэг. Энгийн хүн өөрийнхөө үзэл бодлоор, тогтсон ойлголтоороо юмыг дүгнэдэг, тиймээс тэр сайн муу гэж хэлсэн нь магадгүй жинхэнэ сайн, муу биш. Түүнчлэн хувь хүн, юмыг сайн муу гэж дүгнэхдээ өөрийнхөө үзлийг баримталдаг: “Хэн нэгэн надад сайн байвал би түүнийг сайн гэнэ, Хэрэв ямар нэгэн зүйл надад ашиг тустай байвал би үүнийг сайн гэнэ.” Гэхдээ энэ бүгд магадгүй жинхэнэ сайн биш. Орчлон ертөнцийн мөн чанарын дагуу, Номын дагуу сайн мууг цэгнэх ёстой, яагаад гэвэл энэ нь үүрд өөрчлөгдөхгүй, энэ бол орчлон ертөнцийн зарчим, сайн мууг цэгнэх цорын ганц шалгуур юм. Чин хаан Хятадыг нэгтгэхдээ маш олон хүнийг алсан, олон мужуудын толгойлогчдыг цаазалсан, түүнийг бүх ард түмэн үзэн ядаж хараан зүхсэн. Бусад мужийн эзэд, ард түмэн түүний өлмий доор байсан, бүгд түүнийг бас үзэн яддаг байсан. Үнэндээ, бүгд түүнийг өөрсдийнхөө үзэл бодлоор дүгнэсэн. Түүний Хятадыг нэгтгэх нь зайлшгүй байсан, энэ бол тэнгэрийн тааллаар болсон. Хэрэв тэр тэнгэрийн тааллыг дагаагүй бол тэр ялж Хятадыг нэгтгэж чадахгүй байсан. Энгийн хүний хэрэг явдал зөвхөн ийм төдий л юм. Бид бясалгагч хүний хувьд шүүмжлэлд оролцохгүй. Бясалгагч хүн улс төр сонирхохгүй, эс бөгөөс тэр улс төрч, харин бясалгагч биш.

Хүн төрөлхтөн нэг тодорхой хугацаанд хүрэхэд хуримтлагдсан нүгэл нь маш их болдог, аврагдашгүй их нүгэлтэй болдог. Нүгэл нь маш ихээс өрөө төлж чадахгүй болдог, тэдэнд үеэс үед хуримтлуулж ирсэн тэр их нүглээ наминчлах ямар ч арга байхгүй. Тиймээс тэд устгагдах болно. Яаж устгах уу? Хүн төрөлхтний нийгэмд гарах жижиг гай гамшигаар тэднийг устгана. Дайн дажин бол хамгийн таарсан устгалын хэлбэр, түүх ийм л утга учиртай байдаг.

Үе үеийн гүрнийг үүсгэн байгуулсан эзэн хаан болгон хэд хэдэн шадар жанжидтай байсан, ийм дайчин амь бодь хүний ертөнцөд түүний төлөө тулалдахаар ирдэг байсан. Тэдгээр цэргийн жанжид ийм л тодорхой үүрэгтэй байсан. Тиймээс тэдний зүтгэл алдар гавъяа авчрахгүй, гэхдээ нүгэл ч бас болохгүй, тэд ийм л үүрэг гүйцэтгэх учиртай байдаг. Эрэн зуунуудын тоолшгүй урт он жилүүдийн хугацаанд хичнээн хүн төөрөөгүй үлдсэн вэ?

## **Будда хүнд аврал үзүүлдэг, ивээн тэтгэдэггүй**

Буддын номонд хүнд баян болоход нь туслах ямар ч зүйл байхгүй. Өвчин бол нүглээс болдог, иймээс өвчин эдгээх, эрүүлжихийг ярьдаггүй. Шагжамүни бүх амийг аварна гэж ярьсаны утга нь, хүнийг энгийн хүний гашуун зовлонтой орчноос ангижруулж цаад эрэг дээр, нирвааньд хүргэж өгөхийг хэлсэн. Будда Шагжамүни ингэж л хэлсэн. Өөрөөр яривал тэнгэрийн оронд очуулахыг хэлсэн. Есүсийн ярьсан нь бас ийм утгатай байсан, алийг нь ч нөгөөдхөөсөө өндөр гэж хэлээгүй. Зөвхөн орчин үеийн хүмүүс л ойлгодоггүй. Тэд Будда хүнийг ивээн тэтгэдэг, өвчнийг арилгаж өгнө, баян болгож чадна гэж ярьдаг. Аугаа гэгээрэгчид хэмжээлшгүй хүч чадлаараа хүнийг аварч чадна гэдэг. Энгийн хүмүүс Будда хүнийг аврахыг халамжилж тэтгэж байгаатай адил ойлгодог, иймээс Будда-гаас баян болоход туслаач, өвчнийг арилгаж өгөөч гэх мэтийн зүйл гуйдаг. Үнэндээ Будда иймэрхүү зүйлээр хэзээч хүнийг ивээн тэтгэж байгаагүй. Энэ бол зөвхөн орчин үеийн доройтсон хүн төрөлхтний гажуу ойлголт. Буддын судруудад тийм зүйл байхгүй, тийм учраас би энэ талаар үргэлж ярьдаг. Чи хүж бариад Буддад мөргөж баян болохыг хүсэхэд Будда туслахгүй, чиний баян болох үгүй нь огт хамаагүй .

Чи Буддад мөргөж залбирахад Будда чамайг баян болгох юу ч хийж өгөхгүй харин чамайг энэ шунахай сэтгэлээсээ салахад сургана. Хэрвээ амьдрал чинь үнэхээр хэцүү байвал чиний аюулгүй байдлын тулд материаллаг тусламж үзүүлнэ. Чамд баян болох буян, хувь тавилан байхгүй бол чамд туслахгүй. Өвчний хувьд яривал, Будда үүнийг урьд насны нүглээс болсон гэж үздэг. Зарим хүн Буддын хөргөнд баян болгож өгөхийг гуйж залбирдаг, тэгээд үнэхээр баян болдог. Үнэндээ яаж баян болсон бэ? Тэр Буддын хөрөг дээр Будда байхгүй, мөргөл залбиралаас бий болсон хуурамч Будда байдаг. Бас заримд нь үнэг, могой, үен гэх мэт ариун бус зүйлс шүглэсэн байдаг. Тэр чамд баян болоход тусална, яагаад гэвэл чи түүнд мөргөж гуйсантай адил болсон. Гэхдээ тэр чамд нөхцөлтэй туслана. Энэ орчлон ертөнцөд нэг зарчим байдаг, алдахгүй бол олдохгүй гэдэг. Тэр энэ зарчмыг ашиглаж хүний биетэй болохыг хүсдэг. Хэрэв хүн түүнд мөргөөд баян болгож өгөхийг гуйвал тэр хэлнэ, “Бололгүй яахав!” Харин тэр хүний биенд сайн зүйл байхгүй бол тэр чамайг тоохгүй, баян болгож өгөхийг гуйж залбирч мөргөсөн ч үр дүнгүй. Тэр чиний биед сайн зүйл байгааг мэдвэл чамд баян болоход чинь тусална, хариуд нь тэр чиний сайн зүйлийг авч болно. Чи мөнгө гуйвал тэр мэдээж чамд өгнө. Гэхдээ чи өөрөө мэдэхгүй, алдсан зүйл нь үүрд эргэж олдошгүй, нөхөгдөшгүй хохирол. Хүн зөвхөн нэг удаа амьдардаг биш, дараагийн насандаа бүр ч хэцүүднэ !

## Хүн төрөлхтний доройтол ба аюултай үзэл бодол

Эртний Хятадад хэн нэгэн Бумбад бясалгаж байгаа гэж яривал, хүмүүс түүнийг суурь сайтай байна гэдэг байсан. Будда, Бумба, эсвэл Бурханы тухай ярьсан хүн үнэхээр сайн хүнд тооцогддог байсан. Өнөөдөр ч Буддад бясалгах, Бумбад бясалгахыг ярихад хүмүүс чамайг шоолно. Хүн төрөлхтний ёс суртахууны байдалд айхтар өөрчлөлт гарсан. Хүний ёс суртахууны хэм хэмжээ өдрөөс өдөрт мянган бээрээр доош уруудаж байна, маш хурдан унаж байна. Иймээс хүмүүсийн үзэл бодол доройтож дээр үеийн хүнийг харанхуй бүдүүлэг, мухар сүсэгтэй байсан гэж үздэг. Хүний үзэл бодолд маш том өөрчлөлт гарсан, аймшигтай болсон. Шагжамүни Будда ингэж хэлсэн: “Номын төгсгөлийн үед нийгэмд гарах өөрчлөлт үнэхээр аюултай болно.” Тухайлбал, одоогийн энэ нийгэмд хүний сэтгэл зүрхэнд өөрийгээ барих ёс суртахууны даруулга байхгүй болсон, ялангуяа Хятадад. Гадаадад ч бас адилхан, тэнд зөвхөн өөр хэлбэрээр илэрдэг. Эх газрын Хятадад “Соёлын их хувьсгал”-ын үед хүмүүст байсан зүйлийг “хуучимсаг үзэл бодол” хэмээн нэрлэж үндсээр нь устгахыг оролдсон, Күнзийн номлолд итгэхийг хорьсон. Хүмүүс ёс суртахуунаа барьж байх итгэл үнэмшилгүй болсон, ёс суртахууны хэм хэмжээ гэж байхгүй болсон. Мөн шашинд шүтэн бишрэхийг хориглосон. Хүмүүс муу зүйл хийвэл нүгэл болно, шийтгэл ирнэ гэдэгт үнэмшихгүй болсон.

Хүмүүсийн сэтгэл зүрхэнд нь өөрийгээ барьж байх дотоод хяналт байхгүй болбол тэд юу ч хийж зүрхлэнэ биз дээ? Энэ бол одоогийн хүн төрөлхтний өмнө байгаа хамгийн ноцтой асуудал. Зарим гадаадынхан Хятадад ирж наймаа хийхийг зүрхэлдэггүй, ялангуяа зарим Хятад залуучууд их аймшигтай болсон, хүнийг шуудхан алж чадна, хутгална. Одоо Хятадад гадаад орнуудаас илүү муухай болсон. Хятадын эх газарт гадны гэмт хэрэг алаан, муу зүйлийг харуулсан кино, телевизийн нэвтрүүлэг орж ирэхэд Хятад хүмүүс Хонг-Конг болон бусад орнуудад ийм замбараагүй байдаг гэж боддог. Үнэндээ тийм биш, тэр бол зөвхөн үзэгчдийн сонирхлыг татахын тулд хийсэн киноны хэтрүүлэг юм. Үнэндээ тэндхийн хүмүүс Хятад хүнийг бодвол илүү соёлтой, дэг журамтай. Гэвч Хятадын залуучууд тэдгээр зүйлүүдийг дууриадаг. Яагаад гэвэл Хятад хэсэг хугацаанд гадагш хаалттай байсан, гэнэт эдгээр зүйлийг үзээд гадаадад ийм байдаг гэж боддог.

“Шанхайн эрэг” гэдэг телевизийн олон ангит кинон дээр гардаг луйварчин бизнесмэнүүдийг Хятадад их олон хүн дууриаж байна. Гэхдээ энэ нь гучаад оны үеийн хуучин Шанхайгийн тухай өгүүлдэг. Энэ нь урлагийн хэтрүүлэг, бодит амьдрал дээрээс сэдэвлээгүй юм. Эдгээр гэмт хэргийг харуулсан, нэг нэгнийгээ алсан Хонг Конгийн кинонууд, телевизийн нэвтрүүлэг нь их газрын Хятад хүмүүсийн үзэл санаанд маш муугаар нөлөөлж байна. Хүн төрөлхтний ёс суртахууны байдал өөрчлөгдсөн, Хятадад ч гэсэн ижил хүйстэн, хар тамхичид, хар тамхины наймаачид, зохион байгуулалттай гэмт хэрэг, чөлөөт секс, биеэ үнэлэгчид

бий болсон. Энэ бүгд үнэхээр замбараагаа алдсан! Зарим хүн ингэж ярьдаг: “Ядуу орны юм үзээгүй хүн гэнэт ийм зүйлтэй учирвал бүр хэцүү болдог.” Өөрийгээ барьж чадахгүй хүн юу ч хийхээс буцахгүй. Хүн ийм байдалд хүрэхэд аймшигтай биш гэж үү? Хэрэв цаашдаа ийм байдалтай байвал юу болох вэ? Хүний сэтгэхүйд сайн муугийн талаархи ойлголт нь урвуугаар эргэсэн. Одоо хүмүүс хэрцгий, мэргэжлийн алуурчид дээрэмчдийг биширдэг болсон, ийм зүйлийг хүндэтгэн үздэг болсон.

Хүн төрөлхтний ёс суртахуун эрс доройтсон, бүх дэлхий даяар ийм байгаа. Хүний үзэл бодол үндсээрээ өөрчлөгдсөн. Одоо гоё сайхан нь муухайгаас бага үнэлэгддэг болсон. Нинжин нь хэрцгийгээс дорд үзэгдэх болсон, цэвэр цэмцгэр нь бохир заваанаас дор орох болсон. Нэг жишээ ярья, урьд мэргэжлийн дуучин болоход дуулах арга барилыг сайн эзэмших төдийгүй бас хөгжмийн мэдлэгтэй байхыг шаарддаг байсан. Гэвч одоо тайзан дээр урт арзайсан үстэй, нүүрнийхээ урдуур үсээ задгай унжуулсан, гадаад өнгө үзэмжгүй хүн гараад бахирсан хоолойгоор “Ааа...” гэж хоолой мэдэн орилоод л, телевизээр гараад од болчихдог. Дуу хоолой нь гэж авах юм байхгүй. Ёс суртахууны доройтлоос болоод хүний төсөөлөл өөрчлөгддөг. Үзэшгүй муухай зүйлс гоё сайханд ордог, хойноос нь ухаангүй хөөцөлддөг. Дүрслэх урлагт бас адилхан, муурыг сүүлийг нь бэхэнд дүрээд тойрон гүйлгэхэд тэр нь урлагийн хөрвүүлсэн бүтээл болно. Мөн хийсвэр сэтгэлгээний, төсөөллийн урлаг (импрессионизм, абстракционизм) байдаг. Эдгээр нь юу вэ? Урьд улам гоё сайхан харагдахаар зурах тусам хүмүүс илүү сонирхдог байсан. Харин одоогийн ийм зүйлсийг юу гэж нэрлэх вэ?! Энэ нь “зураачийн” хувь хүний чөлөөт сэтгэлгээ гэгч үзлээс үүдэн гарсан. Хүний мөн чанар ёс суртахууны хязгаарлалтгүй бол ад чөтгөрийн шинж чанар илэрдэг. Хүн ийм байдалд байхад сайхан зүйл хийж чадах юм уу? Хүний төсөөлөл гажуудан муугаар өөрчлөгдөж байна.

Эдгээр зураачид юуны хойноос хөөцөлддөг вэ? Тэд хүний мөн чанарыг чөлөөлөхийг ярьдаг, биеэ барих юмгүй, хяналтгүй, юу хүссэнээ дураараа хийхийг сурталчилдаг. Буддын шашинд ингэж ярьдаг, хүний сэтгэлд ёс суртахууны хэм хэмжээ байхгүй болбол, өөрийгээ барих ёс суртахууны хяналт байхгүй бол хүний илэрхийлсэн зүйл нь чөтгөрийн шинж чанартай болно. Одоогийн урлагийн бүтээлийг хардаа! Энгийн хүн ямар учиртайг нь ойлгохгүй, үнэндээ тэр бүгдэд чөтгөрийн шинж чанар харагдаж байна.

Дэлгүүрийн тоглоомыг ярьвал, урьд хүмүүс хүүхэлдэй худалдаж авахдаа хөөрхнийг нь сонгодог байсан, харин одоо бол аль муухай нь хурдан зарагддаг. Гавлын яс, чөтгөр, тэр байтугай баасны баримал хүртэл тоглоом шиг зарагддаг болсон, улам аймаар харагдах тусам хурдан зарагдана! Энэ нь хүний үзэл бодол өөрчлөгдөж байгааг харуулж байна, муугаар өөрчлөгдөж байгаа биш гэж үү?

Би, хүн төрөлхтний нийгэмд ийм зүйл гарсныг ярихад хүмүүс дорхноо ухаардаг, энэ нь хүний дотоод мөн чанар өөрчлөгдөөгүйг илтгэж байна. Гэхдээ хүн төрөлхтөн ийм маш аюултай хэмжээнд хүртэл гулсан унасан. Би нэг барууны оронд лекц уншихдаа ижил хүйстний тухай ярьсан, барууны орны хүмүүсийн энэ бузар бэлгийн харьцаа нь цус ойртох шиг муу зүйл гэж хэлсэн. Зарим хүн ингэж хэлсэн: “Ижил хүйстэн байхыг улсын хуулиар зөвшөөрсөн”. Сайн мууг цэгнэх шалгуур нь зарим хүний эсвэл олон нийтийн хүлээн зөвшөөрснөөр хэмжигддэггүй. Хүмүүс сайн мууг өөрийнхөө үзэл бодлоор цэгнэдэг. Хүмүүс хэлдэг: “Би түүнийг сайн гэж боддог., эсвэл тэр надад сайн бол, би түүнийг сайн гэнэ.” Эсвэл хүнд аль хэдийн суусан суурь үзэл бодол байдаг, тэр үзэлд нь нийцсэн хүнийг сайн хүн гэж хэлдэг. Олон нийтийн хувьд ч гэсэн адилхан тийм байдаг. Олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн, эсвэл тухайн зорилгод нь харшлахгүй бол хүмүүс сайн гэж үздэг, хүлээн зөвшөөрдөг, гэхдээ тэр нь магадгүй жинхэнэ сайн биш. Орчлон ертөнцийн зарчим, Буддын ном нь хүн төрөлхтнийг болон бусад бүх зүйлийг цэгнэдэг цорын ганц өөрчлөгдөшгүй шалгуур юм. Энэ бол сайн мууг ялгах цорын ганц шалгуур. Би тэдэнд хэлсэн: Илэн далангүй хэлэхэд, танай засгийн газар үүнийг зөвшөөрсөн ч танай бурхан зөвшөөрөөгүй! Үнэндээ хүн төрөлхтөн удаа дараа ийм байдалд хүрэхэд маш аюултай байдалд ордог, хяналтаа алддаг. Одоо яг ийм байдалд хүрсэн. Хэрэв цааш энэ байдлаараа үргэлжилбэл юу болох вэ?! Шагжамүни Будда ингэж хэлсэн: Номын төгсгөлийн үед маш олон ад чөтгөрүүд хүн болж төрөөд сүм хийдийн лам хувраг болж Номыг сүйтгэнэ. Ялангуяа Тайваны их олон нэртэй лам хуврагууд, Буддын сүсэгтнүүд үнэндээ ад чөтгөрүүд. Тэд өөрсдийгөө шашныг үндэслэн байгуулагч багш гэдэг, тэд өөрсдийгөө ад чөтгөрүүд гэдгээ мэдэхгүй. Тэдний амьдрал хүн төрөлхтөнд ирэхээс өмнө урьдчилан төлөвлөгдсөн, дараа нь энэ зохицуулагдсан амьдралын замаараа явж Номыг сүйтгэхээр ирсэн. Хүний ертөнц маш аймаар. Энэтхэгт байдаг их олон нэртэй цуутай гэгдэх багш нарын ихэнхийн биенд нь аварга могой шүглэсэн. Хятадын чигон багш нарын дотор биенд нь үнэг, үен бас могой ч шүглэсэн хүн маш олон байдаг. Номын төгсгөлийн үе бол замбараагүйтлийн үе юм. Японы Аум Шинрикёо шашны удирдагч бол тамын чөтгөр хүн болж төрсөн юм, хүн төрөлхтнийг бусниулахаар ирсэн. Энэ дэлхийн хүмүүс ийм асуудлын дунд байлаа ч энгийн асуудлаа хөөцөлдөөд энэ талаар бодох завгүй. Нийгэм эвгүй байдалтай болж байгааг мэдэрсэн ч ийм хэмжээнд хүртлээ доройтсоныг мэддэггүй, энэ талаар сонсоод бүгд цочдог.

Би зүгээр санаандгүй гарч ирээд энэ Номыг заан тарааж байгаа юм биш. Надад янз бүрийн хэлбэрээр саад учирч байсан. Чи ариун зүйл заан тараахад, хэн нэг нь эсрэг гажуу зүйл тараана, зарим нь үнэн ариун дүр үзүүлнэ, бас хүнийг сайн зүйл хийхийг уриална, гэхдээ түүний зорилго нь сайны тулд биш, өдрийн гэрэл гэгээг ч тэвчихгүй санаатай. Чигон анх гарч ирэхдээ сайн байсан, одоо замаасаа хазайсан. Хүний орчлонд ариун газар олоход хэцүү.

## Төгсгөлийн галавын үеийн хүн төрөлхтөн

Дэлхийн олон ариун шашин бүгд хүнийг аварч чадахгүй болсон. Яагаад гэвэл эртний ариун шашны зарим номыг хойч үеийнхэн нь өөрчилсөн, номлол утгыг нь хойч үеийнхэн нь гажуудуулж тайлбарласан, шашныг мэдлэг боловсролтой адил болгосон. Буддын шашныг философийн гүн ухааны зүйл болгон сурч байна, мөн орчин үеийн шинжлэх ухаанаар тайлбарлагдашгүй зүйлийг бүгдийг нь дээр үеийн хүмүүсийн таамаглал, хоцрогдсон домог яриа гэдэг. Лам хуврагууд, бясалгагчид зөвхөн ном уншдаг, жинхэнэ бясалгадаггүй. Сүм хийдүүд нийгмийн нэг жижиг давхарга болсон, лам хуврагууд албан тушаалын төлөө хоорондоо өрсөлдөнө. Зарим нь Буддын шашны өрөвдөлтэй байдлыг далимдуулан ашиг орлогын хойноос хөөцөлддөг, тэдний зууралдсан сэтгэл нь энгийн хүнийхээс ч илүү. Тэдэнд бусдыг аврах нь бүү хэл өөрсдийгөө аврахад ч тун хэцүү! Бас зарим нэртэй Буддын лам хуврагууд, Бумбын бясалгагчид, Христийн санваартнууд Буддын судар болон Библийг өөрсдийнхөө үзэл бодлын дагуу ба Буддын судрыг өнгөцхөн ойлгосноороо орчуулдаг, хүнийг төөрөлдүүлдэг. Агуу гэгээрэгчийн хэлсэн үг бүгд маш гүн утга агуулгатай, энэ нь бясалгагч түвшнөө байнга дээшлүүлэхэд Буддын номын янз бүрийн түвшин дэх удирдах нөлөө илэрдэг. Аугаа гэгээрэгчдийн хэлсэн анхны үгийг өөрчлөх нь Номыг эвдэж байгаа юм.

Хүмүүст Буддын судар, Библийг ойлгоход туслах зорилгоор бичигдсэн тэдгээр тайлбарууд нь Буддын ярьсан үгний утгаас маш хол, тэр ч байтугай бүр өөр зүйлүүд юм. Тэр өчүүхэн ойлголт нь тэдний өөрсдийнх нь түвшин дэх ойлголт, энгийн хүнийхээс арай жоохон дээгүүрх ойлголт юм. Дээд түвшний ойлголт тэдэнд байхгүй, яагаад гэвэл тэр түвшинд бясалгаж хүрээгүй. Тэд Рулай түвшинд хүрээгүй байж яаж Рулайгийн дээд түвшинд хэлсэн үгний жинхэнэ утгыг ойлгох юм? Тэдгээр гар бичмэлүүд нь зөвхөн л Номыг гажуудуулна, хүнийг аварч чадахгүй. Ашиг хонжооны сэтгэлээр бичигдсэн номнууд Буддад бясалгадаг хүнийг зохиолчийн үзэл санааны хүрээнд хязгаарлачихдаг. Тэр ч байтугай, шашныг одоогийн нийгмийн шаардлагад нийцэх ёстой гэж үздэг хүн шашны мөн чанарыг эвдэх бодолтой. Буддын ном бол тэнгэрийн зарчим, очир эрдэнэ лугаа өөрчлөгдөшгүй, эвдэршгүй. Буддын номын дагуу дээшлэхийн оронд Буддын номыг ёс суртахуун нь доройтсон хүн төрөлхтөнд нийцүүлэх гэж оролдсон хүн хэр их нүгэл үйлдэж байгаа нь ойлгомжтой. Тэдгээр ном гаргаж Буддын номыг хамаагүй тайлбарлаж бичсэн хүмүүс ариун Номыг ноцтойгоор үймүүлсэн учраас үнэндээ аль хэдийн тамд уначихсан юм.

Хүмүүс урьдах амьдралуудынхаа туршид маш их муу зүйл хийж асар их нүгэл хураасан, энэ нь ариун итгэл бишрэл гарахад саад болох нөхцөл болдог. Зарим хүн урьд насандаа бясалгаж байсан, гэхдээ сайн бясалгаж чадаагүйн улмаас янз бүрийн зууралдсан сэтгэлээ орхиогүй, бясалгал нь үр дүнд хүрээгүй, зөвхөн бага зэрэг буян



л хураасан. Тийм хүмүүс дахин хүн болж төрөхдөө гол төлөв ер бусын чадвартай ирдэг, тэдний доод түвшинд нээгдсэн тэнгэрийн мэлмийд өөр орон зайн бага сага зүйлс харагддаг. Тэгээд энгийн хүний янз бүрийн нэр ашгийн сэтгэлд автан олон янзын шашны бүлгийг байгуулдаг. Өнгөн дээрээ тэд нинжин сайн байхыг заадаг ч сэтгэлийнхээ гүнд нэр ашгийн хойноос хөөцөлдсөн далд санаатай. Аугаа гэгээрэгчид хүн аврах өөрийн гэсэн диваажинтай (тэнгэрийн орон) байдаг, харин тэдгээр хүмүүс хаана хүнийг аврах юм? Хуурамч чигон багш нар бас адилхан, зарим нь Будда болох санаатай, зарим нь урьд насандаа өөрийгөө Будда байсан гэж боддог. Биенд нь амьтан шүглэсэн зарим хүн тэдгээр чигон багш нарыг дэмждэг, тэднийг “Удам дамжсан их багш” гэх мэтээр өргөмжилдөг. Үүнд тэдгээр хуурамч чигон багш нарын сэтгэл хөөрнө, тэд өөрсдийгөө болон бусдыг л хуурч байгаа юм. Үнэндээ тэд хүн болж төрсөн ад чөтгөрүүд, хүн төрөлхтнийг бусниулахаар ирсэн юм.

Хүний ертөнц харгис муу зүйлсээр дүүрээд аюултай байдалд хүрсэн, олон зууны турш хуурамч шашин, харгис шашин, бас маш олон өөрчлөгдсөн шашнууд дэлгэрсэн, аль нь жинхэнэ аль нь хуурамч болохыг ялгахад хэцүү. Тэдгээр тэрс үзлийн шашны, хар дом, тахил мөргөлийн шашны номлолууд нь харгис юм, гэхдээ үүнд итгэдэг, тахин шүтдэг, тэдгээр шашны толгойлогчдыг биширдэг хүмүүс байдаг. Энэ нь хүн ёс суртахуунаа алдсаныг харуулж байгаа биш үү? Хүн яагаад ад чөтгөрийн зам руу ордог вэ? Тэр хүмүүсийн ихэнх нь хар домын увидаст суралцаж хүн хорлохын төлөө байдаг, хүнд муу зүйл хийхийг л хүсдэг, хожим өөрт нь ямар хариу ирэхийг боддоггүй. Эртнээс уламжлагдан ирсэн ариун шашнууд Номын төгсгөлийн үед хүнийг аварч чадахгүй болсон, тоо томшгүй ад чөтгөрүүд хүний орчлонд Номыг сүйтгэхээр, хүний нийгмийг бусниулахаар ирсэн. Хүн төрөлхтөнд сэтгэлээ захирах хууль байхгүй болсон, ёс суртахууны хэр хэмжээгээ алдсан. Тоолшгүй олон ад чөтгөрүүдийн удирдлагаар, хийхгүй муу зүйл гэж байхгүй болсон, ёс суртхууны хэм хэмжээ болон шалгуур нь хамгийн хурднаар доош гулсан унаж байна. Хүмүүсийн үзэл бодол, төсөөлөл нь бүгд өөрчлөгдсөн, муухайг гоё сайхнаас илүүд үздэг болсон, нинжин ариун нь хэрцгий муугаас дор орсон, цэвэр цэмцгэр нь хайш яайш, замбараагүйгээс дор болсон, шинийг хуучнаас илүүд үзэхгүй, анхилуун нь өмхийгээс сайхангүй болсон. Эрэгтэй хүн урт үстэй болж эмэгтэй хүн богинохон үстэй болсон, билэг нь (инь) сэргэж арга нь (ян) буурай болсон, арга билэг нь солигдчихсон. Уран бүтээлүүд нь ёс суртахууны хэм хэмжээнээс гажсан, хүнлэг мөн чанарыг задгай тавих болсноор ад чөтгөрийн мөн чанар түрэн орж ирсэн. Мөн импрессионизм (чөлөөт сэтгэлгээний), абстракционизм (хийсвэр сэтгэлгээний) зүйл бий болсон, өнөөгийн хүмүүсийн урвуу үзэл бодолд замбараагүй сараачсан зураг урлагт тооцогдох болсон. Хаа нэгтээ хэсэг хог овоолж байрлуулаад тэр нь орчин үеийн уран баримал, хөшөө болчихно, хөгжмийн хувьд “диско”, “рок-н-ролл” хэмээх зүйл байдаг, чамин зааланд чанга хашгираан шуугиан нүргэлнэ. Сохор, доголон мөн жигшмээр гадаад

байдалтай хүн сөөнгө хахир хоолойгоор дуулаад л радио телевизийн хүчээр од болчихдог, хүүхдийн тоглоомын хувьд гэвэл аль муу ёрын тоглоом нь дэлгүүрт хурдан зарагддаг.

Хүн төрөлхтний оюун санааны хүрээнд ариун бодол, өрөвдөх сэтгэл байхгүй болсноор хөөцөлддөг хүсдэг зүйлст нь том өөрчлөлт гарсан. Нэр төр, эд баялгийн төлөө хүний амь бүрэлгэнэ, галдан шатаана, гэмгүй хүн лүү буруугаа чихнэ. Мөнгийг хүнээс илүүд үзнэ, хүмүүсийн харьцаа мөнгөн дээр тогтдог болсон. Мөнгөний төлөө янз бүрийн туйлын жигшмээр зүйлс хийдэг болсон, садар самууныг сурталчилсан зүйлс, зар сурталчилгаа, дүрс дууны бичлэгүүд хаа сайгүй болсон. Хүмүүс мөнгөний төлөө хүнд хор хөнөөл учруулахаас буцахгүй, мөн хар тамхины үйлдвэрлэл, зөөвөрлөлт, наймаа хийнэ. Хар тамхинд автсан хүн мөнгөний төлөө хулгай, дээрэм хийнэ, мөнгөний залилан хийнэ, үнэтэй хар тамхи авахын тулд юу ч хийхээс буцахгүй. Телевизийн нэвтрүүлгээр, сонин сэтгүүлд болон уран зохиолд чөлөөт сексийг их сурталчилдаг, үе удмын хүмүүс хоорондоо цус ойртдог болсон, ийм байдалд хүртлээ доройтсон. Жигшмээр ижил хүйстэн гарч ирсэн нь одоогийн оюун санааны гажуудал, ухамсрын доройтлын илрэл юм. Зохион байгуулалттай гэмт хэрэг хаа сайгүй гарах болсон, үүнд ад чөтгөрийн мөн чанартай, хүчирхийлэл хөөцөлддөг залуучууд татагддаг, гэмт хэргийн толгойлогчдыг бахархан дуурайх хүнээ болгосон, тэгээд тэдний хойноос ордог.

Түүхэнд маш олон аугаа гэгээрэгчид, зөнч мэргэн хүмүүс энэ үед хүн төрөлхтөнд маш том гай гамшиг, сүйрэл болно гэж урьдчилан хэлсэн. Өнөөдрийн хүн төрөлхтөн урьдны үзмэрчдийн зөгнөснөөс ч илүү муудсан, сайн хүнийг олоход улам хэцүү болсон. Хүн урьдах амьдралуудынхаа туршид маш их муу зүйл хийснээс болж асар их нүгэл хуримтлагдсан, үүдээрээ гараад л азгүй тохиолдолтой учирдаг. Хүмүүс үүнийг урьд насандаа үйлдсэн үйлийн өрөө төлж байна, нүглээ наминчилж байна гэдгээ мэддэггүй. Хүмүүс түүнд муу хандахад хүлцэн тэвчиж чаддаггүй харин “Чи надад муу юм хийж байвал би чамд хариуд нь бүр ч муу юм хийнэ дээ” гэдэг. Над руу хүн халдахгүй бол би халдахгүй, халдвал би яасан ч зүгээр өнгөрөөхгүй гэдэг үгнээс ч илүүгээр хийнэ. Урьдны нүглээ хариулаагүй байж дахин шинэ нүгэл нэмнэ, түүний биен дээрх нүгэл нь аймшигтай их! Хүн төрөлхтний ёс суртахуун маш хурдан доош унаж байна, аль хэдийн аюулын ирмэг дээр ирсэн. Үнэндээ хүн болгон урьдах амьдралуудынхаа туршид хүн төрөлхтний ёс суртахуун доройтох шалтгаанд оролцсон. Хүн төрөлхтөн ёс суртахуунаа алдсан үед дэлхийд удаа дараа гай гамшиг тохиолдож байсан. Энэ бол Номын төгсгөлийн галавын үе юм.

## Жинхэнэ бясалгал

Жинхэнэ бясалгаж буй шавь нар минь, миний та бүхэнд заасан нь Буддад бясалгах, Бумбад бясалгах Ном юм шүү. Гэвч та нар энгийн хүмүүсийн дунд эрх ашиг чинь хохироход надад зовлон тоочоод байх юм. Харин өөрийнхөө энгийн хүний зууралдсан сэтгэлээ орхиж чадахгүй байгаадаа санаа зовохгүй, үүнийг бясалгал гэх үү? Энгийн хүний сэтгэлээ орхиж чадах үгүй нь жинхэнэ дээд амь бодийн замаар яваа хүнд амин сорилт юм. Жинхэнэ бясалгагч болгон үүнийг давах ёстой, энэ бол бясалгаж байгаа хүн ба энгийн хүн хоорондын зааг юм.

Үнэндээ, энгийн хүмүүсийн дунд та нарын нэр хүнд, ашиг сонирхол, сэтгэл чинь хохироход чи зовж байвал чиний энгийн хүний зууралдсан сэтгэл орхигдоогүй байгаан шинж. Та нар санаж яв, бясалгал бол өөрөө зовлонтой биш, асуудлын гол нь чи энгийн хүний зууралдсан сэтгэлээ орхиж чадахгүй байгаад юм. Чамд зөвхөн нэр хүнд, ашиг сонирхол, сэтгэлээ орхиход зовлонтой санагдаж байгаа юм.

Та нар ариун гэгээн, юутай ч зүйрлэшгүй сайхан тэнгэрийн орноос унаж ирсэн, яагаад гэвэл тэр түвшинд та нарт зууралдсан сэтгэл гарснаас юм. Харин бусад оронтой харьцуулахад хамгийн бузар энэ дэлхийд унаж ирснийхээ дараа яаравчлан бясалгаж түргэн буцахын оронд энэ заваан дэлхийн бузар зүйлстэй зууралдаад тавихгүй харин ч үл ялих хохирол амссандаа шанална. Та нар мэдэх үү? Будда та нарыг аврахын төлөө энгийн хүмүүсийн дунд хоол гуйж явсан. Би өнөөдөр дахиад энэ том хаалгыг нээж та нарыг аврахын тулд аугаа Номыг заан тарааж байна. Үүний төлөө би тоолшгүй хүнд бэрхшээлийг туулахдаа зовлон гэж боддоггүй. Та нарт орхиж чаддаггүй өөр юу байна? Чи сэтгэлдээ орхиж чадахгүй байгаа зүйлээ тэнгэрийн орон луу авч явж болно гэж үү?

## Гэгээлэг бай

Би хэсэг сурагчдад, нэн догшин ширүүн бодол гарах нь бодлын нүглээс болдог гэж хэлсэн. Харин одоо маш олон сурагчид өөрийнхөө энгийн үед гардаг бүх муухан бодлыг бодлын нүгэл гэж ярьдаг, энэ нь буруу юм. Чамд ямар ч муу бодол байхгүй болчихвол чи юуг бясалгах юм? Чи тийм цэвэр ариун болчихвол Будда болчихно биз дээ? Бид энэ буруу ойлголтын талаар ярьж байна. Чамд зөвхөн маш харгис муу бодол гарвал, эсвэл Багшийг, Аугаа номыг, бусдыг загнаж зүхэх гэх мэт бодол гарахад үүнийг дарж арилгаж чадахгүй бол энэ нь бодлын нүгэл юм. Бас зарим хүчтэй биш бодлын нүгэл байдаг, гэхдээ жирийн бодол санаатай адилгүй. Ухаалаг ханд, үүнийг сайн ялгаж чаддаг бай.

## Ухамсар

Хүний орчлон бол нүглийн нүдийг гурилаар хуурсан булингартсан газар. Рулай дэлхийд бууж ирэхдээ үргэлж чимээгүй, мэдэгдэлгүйгээр бууж ирдэг. Ариун номыг заан тараахад гажуу урсгалын номлолууд үймүүлэх нь гарцаагүй. Бумба ба ад чөтгөрийн номлол дэлхийд зэрэгцэн оршиж түгэн дэлгэрдэг. Хүн ухамсартаа тулгуурлан үнэн худлыг таньж чадна. Үнэхээр хувь тавилантай хүмүүс ухамсраараа таньж ирэн ар араасаа Бумбын үүдээр орж Номыг олж авдаг. Ариун ба гажууг ялган таньж жинхэнэ судрыг олно, өөрийн биеэ хөнгөлж оюун ухаанаа баяжуулна, санасандаа хүрч Номын хөлөг онгоцоор хөвнө, ёстой гайхамшигтай! Тэд хичээнгүйлэн урагшилна, төгс гэгээрэлд хүртлээ явна.

Хүний хорвоод төөрсөн хүний ухамсар дорой, мөнгөний төлөө амьдарч эрх мэдлийн төлөө үхдэг, үл ялих ашгийн төлөө баярлана, гутрана, нэг нэгэнтэйгээ өрсөлдөн тэмцэнэ, бүх амьдралынхаа туршид нүгэл хураана. Ийм хүн Номын дуу сонсвол инээд нь хүрнэ, амнаас нь “мухар сүсэг” гэсэн үг л гарна, түүний сэтгэлд үүнийг ойлгоход хэцүү, үнэмшихгүй нь лавтай. Ийм хүнийг мулгууд тооцож болно, түүнийг аврахад хэцүү. Их нүгэл нь биеийг нь орооно, ухамсар нь түгжигдэнэ, мөн төрөлх чанараа алдана.

## **Яагаад харагддаггүй вэ?**

Харвал үнэмшинэ, харагдахгүй бол үнэмшихгүй гэдэг бол мулгуу гэжүүд хүний бодол юм. Төөрөлтийн дунд байгаа хүн их нүгэл хураадаг. Төрөлх мөн чанараа алдсан хүн яаж харах юм. Эхлээд ухамсарла, дараа нь харна. Сэтгэлээ бясалгаж нүглээ арилгасны дараа төрөлх чанар нь сэргэж хардаг болно. Гэхдээ хардаг ч бай хардаггүй ч бай гэгээлэг хүн ухамсраараа төгс гэгээрэлд хүрдэг. Зарим хүн харж чаддаг, зарим нь харж чадахгүй, энэ нь тэдний түвшнээс хамаардаг, тэдний төрөлхийн суурьнаас шалтгаалдаг. Бясалгагчдын ихэнх нь харж чаддаггүй, яагаад гэвэл харахыг хүсдэг, хүсэх бол зууралдсан сэтгэл, хэрэв тэд энэ сэтгэлээ орхихгүй бол харж чадахгүй. Ихэнх тохиолдолд энэ нь нүглийн саадаас болдог, эсвэл таатай бус нөхцөлөөс болдог, эсвэл бясалгалын аргаас шалтгаалдаг, учир шалтгаан олон янз байдаг, хүн бүрийн шалтгаан өөр. Харж чаддаг хүн байсан ч түүнд тодорхой харагдахгүй, зөвхөн ийм байдалд үнэнийг ухамсарлана. Хэрвээ хүн, биеэрээ тэнд байгаа юм шиг бүхнийг тов тодорхой харж чадвал энэ хүний гон нь нээгдсэн юм. Тэгвэл цааш бясалгах боломжгүй болно, яагаад гэвэл ухамсарлах зүйл байхгүй.

## **Номыг сурах**

Боловсролтой хүн Аугаа номыг сурахдаа нэг чухал асуудлыг анхаарах ёстой, энэ нь Аугаа номыг энгийн хүний онолын бүтээлийг судалдаг шиг үзэж, нэртэй хүний үгнээс хэрэгтэйгээ сонгон авч өөрийнхөө үйлдэлтэй харьцуулдаг шиг сурч болохгүй, энэ нь бясалгагчийг дээшлэхэд нь саад болдог. Бас зарим хүн Аугаа номыг их гүн утга агуулгатай, бясалгалыг өөр өөр түвшинд удирдах чадвартайг нь сонсчихоод үг бүрчлэн судалдаг, эцэст нь юу ч олдоггүй. Улс төрийн хичээл үздэг шиг урт хугацааны туршид хэвшил болсон арга нь бясалгалд саад болдог, Фа-г (Номыг) буруугаар ойлгуулдаг.

Та нар номыг сурахдаа, битгий ямар нэгэн асуудлыг шийдэх гэж тэр талын зүйлийг хайж, барьж аван судлаарай, тэгвэл энэ нь далд хэлбэрийн зууралдсан сэтгэл болно (яаралтай асуудлыг шийдэхэд хамаатай зүйл л биш бол). Аугаа номонд жинхэнэ ёсоор суралцахыг хүсвэл ямар нэгэн зорилго тавилгүйгээр сур. Жуан Фалунь номыг уншиж дуусах бүрдээ нэг зүйлийг ойлгож авсан бол тэр нь дээшлэлт, чи нэг удаа уншиж дуусаад ч гэсэн нэг асуудлыг ойлгосон бол бас жинхэнэ ахиц юм.

Үнэндээ, чи бясалгалын явцад бага багаар нэг мэдэхэд л дээшилчихдэг. Юу ч битгий хүс, тэгвэл бүхнийг олж авна гэдгийг санаж яваарай.

## Яаж зааварчлага өгөх вэ?

Газар болгонд Аугаа номын сайн ойлголттой маш олон дадлагажуулагчид байдаг, тэд биеэрээ үлгэр жишээ үзүүлдэг, бас бясалгалыг сайн зохион байгуулдаг. Гэхдээ бас сайн хийж чаддаггүй дадлагажуулагчид байдаг, гол нь ажиллах арга барил дээр нь илэрдэг. Жишээ нь, дадлагажуулагч сурагчдыг өөрийн үгээрээ байлгахын тулд ажил зохион байгуулахдаа бясалгал хийдэг газар тушаах хэлбэрээр үүрэг даалгавар өгдөг, ингэж болохгүй. Ном сурах юм бол сайн дурын хэрэг. Хэрвээ сурагч сэтгэлээсээ хийх ямар ч хүсэлгүй байвал юу ч хийлгэж хэрэггүй, хийлгэвэл харин ч зөрчил үүснэ. Ийм асуудлыг засахгүй бол зөрчил хурцдах нь дамжиггүй, энэ нь хүмүүсийг Ном сурахад ноцтой муугаар нөлөөлнө.

Үүнээс гадна зарим дадлагажуулагчид баттай эх сурвалжгүй мэдээлэл тараана, эсвэл ямар нэгэн зүйлийг дуулиан болгон ярьж бусдыг өөртөө татах, өөрийнхээ үгэнд оруулах, нэр хүндээ өсгөх бодолтой, эсвэл хачин зүйлс сэдэж гаргадаг, энэ бүгд болохгүй. Манай дадлагажуулагчид сайн дураараа хүнд үнэ төлбөргүй үйлчилнэ, тэд нар багш биш. Мөн тийм зууралдсан сэтгэлтэй байж болохгүй.

Тэгвэл бид яаж дадлагажуулагчийн ажлыг сайн хийх вэ? Юуны өмнө өөрийгөө сурагчдийн адил үз, тэднээс өөрийгээ битгий дээгүүр тавь. Чамд ямар нэгэн зүйл ойлгомжгүй байвал даруухнаар бусад сурагчидтай зөвлөлд, хэрэв алдаа гаргасан бол чин сэтгэлээсээ ингэж хэл: “Би ч гэсэн та нарын нэгэн адил бясалгагч, алдаа гаргахгүй байх хэцүү. Би энэ зүйлийг буруу хийчихлээ, яаж хийвэл зохистой байдлаар нь хамтдаа хийе”. Юмыг чин сэтгэлээсээ хамтын хүчээр сайн хийхийг хүсвэл ямар үр дүн гарах вэ? Хэн ч чамайг муу гэхгүй, харин Номоо сайн үздэг, уужим сэтгэлтэй хүн гэнэ. Аугаа ном бидэнтэй хамт байна, та бүхэн сурч байна. Сурагчид дадлагажуулагчийн үг, үйлдлийн сайн муу болохыг Аугаа номоор цэгнэж чадна, тэдэнд маш тодорхой харагдана. Чамд өөрийгөө бусдаас илүү гэсэн бодол гарахад л, сурагчид чиний зан чанар сайнгүй гэж мэднэ, иймээс даруу төлөв байвал юмыг сайн хийж чадна. Зөвхөн Номыг сайн сурснаар нэр хүнд чинь өснө. Бясалгагч хүн ямар ч алдаа гаргахгүй байж чадах уу?

## **Хоосон гэж юу вэ?**

Хоосон гэж юу вэ? Ямар ч зууралдах сэтгэл байхгүй бол жинхэнэ хоосон. Энэ нь материаллаг талын хоосон биш. Харин Зэн Буддизмын үе аль хэдийн төгсч заан тараах зүйлгүй болсон. Олон зууны эцэст Номын гажуудлын энэ үед зарим судлаачид үүний хоосон номлолыг философийн гүн ухааны үндэс мэт үзэн ухаангүй, бодлогогүй зуурч барьчихаад салдаггүй. Харин үүнийг үндэслэгч Бодьдарма өөрөө хэлэхдээ, зөвхөн зургаан үед уламжлагдах ном, дараа нь уламжлан дамжуулах зүйлгүй болно гэсэн. Яагаад үүнийг ойлгохгүй байгаа юм? Тэдний ярьдгаар бүгд хоосон, ном байхгүй, Будда оршдоггүй, дүр төрх байхгүй, өөрөө ч оршдоггүй, оршихуй байхгүй гэвэл Бодьдарма гэж хэн бэ? Хэрвээ Ном байхгүй бол Зэн Буддизмын хоосон онол гэж юу вэ? Будда оршдоггүй, дүр төрх гэж байхгүй бол Шагжамүни гэж хэн бэ? Чамд нэр байхгүй, дүр төрх байхгүй, өөрөө ч байхгүй, оршихуй байхгүй, тэр чигтээ хоосон гэвэл идэж уух ямар хэрэгтэй юм? Хувцас өмсч яах юм? Энэ бүгд нүдийг чинь ухаад авсантай ямар ялгаатай юм? Чи өөрийгөө энгийн хүний хүсэл сэтгэлд хэр их автсанаа хардаа. Рулайгийн хоосон гэж хэлсэн утга нь энгийн хүний сэтгэлийг юу ч үлдээлгүй бүрмөсөн орхивол жинхэнэ хоосон юм. Сансар ертөнц бол угийн бодит, үүсэн бий болдог, оршин тогтнодог, яаж хоосон байж болох юм. Рулайгаас доод ном богино хугацаатай, заасан нь байхгүй болох нь дамжиггүй. Архадын ном Буддын ном биш! Үүнийг ухамсарла! ухамсарла!

## **Тууштай байх**

Багшийг байхад чи их итгэлтэй, гэхдээ багш байхгүй бол бясалгах сонирхолгүй, багшийн төлөө бясалгал хийж байгаа юм шиг, сэтгэл хөдлөлөөр ирсэн юм шиг, энэ бол дундаж хүний нэг том дутагдал. Шагжамүни, Есүс, Лаози, Күнз яваад хоёр мянга гаруй жил болж байна, тэдний шавь нарт багш байхгүй бол бясалгаж чадахгүй мэт хэзээ ч санагддаггүй. Бясалгах бол чиний өөрийн хэрэг, хэн ч чиний өмнөөс бясалгаж өгч чадахгүй, багш бол номын зарчмын зөвхөн өнгөцхөн хэсгийг л заадаг. Сэтгэлээ бясалгах, хүсэл шуналаасаа салах, оюун ухаанаа соён гэгээрүүлэх, өөрийгээ төөрөлдлөөс гаргах энэ бүгд бол чиний өөрийн хариуцлага. Зүгээр сонирхол төдий ирсэн бол сэтгэлийн тэнхээ дутна. Энгийн хүний нийгэмд ороход төрлөх мөн чанараа мартах нь лавтай. Хэрвээ итгэл үнэмшилдээ баттай зогсч чадахгүй бол найдваргүй, амьдралынхаа эцэст юунд ч хүрч чадахгүй. Дахиад ийм хувь тавилан хэзээ олдох юм, маш хэцүү!

## **Буддын шашин бол Буддын номын хамгийн өчүүхэн, буурай хэсэг юм**

Хүмүүс ээ! Буддын шашныг “Жэнь, Шань, Рэн” Аугаа номтой (Фа) бүү зүйрлэ, энэ бол зүйрлэшгүй. Хүмүүс Буддын шашны судрыг Ном (Фа) гэж хэлээд заншчихсан. Үнэндээ Сансрын биет бол аугаа уужим том, Буддын орчлон ертөнцийн танин мэдэхүйгээс давсан. Бумбын тайжи онол ч гэсэн орчлон ертөнцийн доод түвшний ойлголт, энгийн хүний давхаргад бол жинхэнэ Фа оршдоггүй, орчлон ертөнцийн захын багахан үзэгдлүүд оршдог учраас хүн бясалгаж болдог. Энгийн хүмүүс энэ хамгийн доод хүмүүний давхаргад оршдог болохоор Буддын жинхэнэ Номыг мэдэхийг зөвшөөрдөггүй. Гэхдээ хүмүүс Буддад хүндлэл бишрэлтэй байвал бясалгах хувь тавилангийн үр сууж болно, бясалгагч тарни ном уншаад дээд амь бодийн хамгаалалд багтаж болно, сахил санваарыг дагаснаар бясалгагчийн норм хэм хэмжээнд хүрч болно гэж мэргэн гэгээн хүмүүсээс сонссон. Түүхийн туршид гэгээрсэн хүний үгнээс Буддын Номыг хайсан хүмүүс үргэлж байсан. Рулай Буддын үгнүүд нь Буддын мөн чанарын нэгдэл, мөн Буддын номын илрэл гэж хэлж болно. Гэхдээ энэ нь орчлон ертөнцийн жинхэнэ Фа биш, урьд хүмүүст Буддын номын жинхэнэ илрэлийг мэдэхийг туйлаас зөвшөөрдөггүй байсан. Буддын Ном (Будда Фа) гэж юу болохыг зөвхөн өндөр түвшинд бясалгаж хүрэхэд ойлгоно, иймээс хүмүүст бясалгалын жинхэнэ мөн чанарыг мэдэхийг бүр ч зөвшөөрдөггүй байсан. Фалунь Дафа хүн төрөлхтний бүхий л түүхийн туршид хамгийн анх орчлон ертөнцийн мөн чанарыг (Буддын Ном) нээж өгсөн. Энэ нь хүмүүнд тэнгэрт гарах шат тавьж өгсөнтэй адил, иймээс чи орчлон ертөнцийн Аугаа номыг Буддын шашинтай зүйрлэж яаж болно вэ?

### **Билгүүн ухаан гэж юу вэ?**

Хүний нийгэм дэх нэртэй эрдэмтэд, янз бүрийн мэргэжилтнүүдийг аугаа хүмүүс гэж үздэг. Үнэндээ тэд тун ялихгүй юм, яагаад гэвэл тэд энгийн хүмүүс. Тэдний мэдлэг бол зөвхөн хүний нийгмийн орчин үеийн шинжлэх ухаанаар танин мэдсэн тэр өчүүхэн зүйлс. Хүн төрөлхтний нийгэм асар уудам орчлон ертөнцийн хамгийн макро хэмжээнээс хамгийн микро хэмжээний хооронд яг дунд нь, хамгийн гадна давхаргад, хамгийн гадаргууд нь оршдог. Амь бодь нь ч гэсэн хамгийн доогуур орших хэлбэртэй, иймээс түүний бие бодь ба оюун санааны талаархи танин мэдэхүй нь тун ялихгүй, өнгөцхөн бөгөөд өрөвдөлтэй. Энгийн хүн бүх хүн төрөлхтний мэдлэгийг эзэмшсэн ч энгийн хүн хэвээрээ л үлдэнэ.



## Тэтгэвэрт гарсны дараа бясалгах

Миний лекцэнд ирж суусан зарим сурагчдын суурь нь дажгүй байсан, гэвч тэд ажил төрөл ихтэй завгүйгээс болоод бясалгахаа больсон, маш харамсалтай! Хэрэв тэд дундаж нэг энгийн хүмүүс байсан бол би юу ч хэлэхгүй, юу дуртайгаа хийг гэнэ. Гэвч тэдгээр хүмүүс амлалт тангарагтай хүмүүс. Хүн төрөлхтний ёс суртахуун өдрөөс өдөрт маш огцом доош унаж байна, бүх энгийн хүмүүс тэр давалгаанд хамагдаж байна. Тэд Бумбаас улам бүр холдож байгаа учраас бясалгалаар буцаж харихад улам хэцүү болсон. Үнэндээ бясалгалын үндсэн утга учир нь бол хүн сэтгэлээ бясалгах юм, тухайлбал төвөгтэй ажлын орчин бол зан чанараа дээшлүүлэхэд яг тохиромжтой нөхцөл юм. Чи тэтгэвэртээ гараад бясалгахад хамгийн тохиромжтой тэр нөхцөлөө алдаж байгаа юм биш үү? Чамд ямар ч зөрчил байхгүй болчихвол чи яаж бясалгах юм? Тэгвэл яаж дээшлэх юм? Хүний амьдрах хязгаартай, ихэнхдээ чи бүхнийг сайн тооцоолж чаддаг, гэхдээ үлдсэн насандаа амжих эсэхийг хэлж мэдэх үү? Бясалгал бол тоглоом биш, энгийн хүний ямар ч зүйлээс илүү чухал, бодсоноор зүгээр болчихгүй. Хэрэв чи энэ боломжоо алдвал зургаан замын тойрогт дахиад хэзээ хүн болж төрөхөө яаж мэдэх юм! Ийм хувь заяа зөвхөн нэг л удаа тохиолдоно. Чи зууралдсан зүүд зэрэглээ шиг төөрөгдлөөсөө салах цагт ямар боломжоо алдсанаа ухаарах болно.